



Олборлох салбарт олон
нийтийн хэлэлцүүлэг
хийх удирдамж





Канадын Гадаад Хэргийн Яамны
санхүүжилтээр MERIT төсөл хэрэгжиж байна.



CESOSACO



WUSC EUMC
Education Changes the World

3 давхар, Нейшнл Таймс Ньюс Тауер, Худалдааны гудамж, 1-р хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар – 15160, Монгол улс
Утас: (976) 7610-5000, Цахим хаяг: support@merit.mn,

2017 оны 6 сар

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГС	4
1. УДИРТГАЛ	5
2. ҮНДЭСЛЭЛ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	5
3. ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ГЭЖ ЮУ ВЭ?	6
4. ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	6
5. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮНДСЭН ЗАРЧМУУД	7
6. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЕ ШАТУУД	8
1-р шат: Асуудлыг тодорхойлох, хүсч байгаа үр дүн	8
2-р шат: Оролцогч талууд / зорилтот бүлгийг тодорхойлох нь	8
3-р шат: Хэлэлцүүлгийн хугацааг тогтоох нь	9
4-р шат: Мэдээлэл боловсруулах нь	10
5-р шат: Мэдээлэл хүргэх ба санал авах хэлбэрүүд	10
6-р шат: Нэмэлт хэлэлцүүлэг хийх хэрэгцээ	11
7-р шат: Саналуудыг нэгтгэн дүгнэж эцсийн шийдвэрт тусгах нь	11
8-р шат: Эцсийн шийдвэр болон түүний хэрэгжилтийн хуваарь / хүчин төгөлдөр болох өдрийг мэдэгдэх нь	12
7. ШИЙДВЭР ГАРГАЛТЫН ДАРААХ АРГА ХЭМЖЭЭ	12
Хяналт үнэлгээ, шинжилгээ	12
Засвар өөрчлөлт хийх нь	12
8. ХАВСРАЛТ	13
1-р хавсралт: Олборлох салбарт оролцогч талуудын хэлэлцүүлэг хийх хууль, эрх зүйн үндэслэл	13
2-р хавсралт: Жендэрийн тэгш байдлын тухай	15
3-р хавсралт: Олон нийтийн тасралтгүй үргэлжлэх оролцоо	17
4-р хавсралт: Компанийн нийгмийн хариуцлагын хяналтын хуудас	18
5-р хавсралт: Хэлэлцүүлгийн арга хэлбэрүүд	20
IX. АШИГЛАСАН МАТЕРИАЛ	26
Ашигласан материалын линк	

ТОВЧИЛСОН ҮГС

КМУБ	Канад улсын Мэргэжлийн үйлчилгээний байгууллага
КНХ	Компанийн нийгмийн хариуцлага
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
КГХЯ	Канад улсын Гадаад хэргийн яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖТБ	Жендэрийн тэгш байдал
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
ОНХАГ	Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ
ЖТБХТХ	Жендэрийн тэгш байдлыг хангах тухай хууль
ХШҮ	Хяналт шинжилгээ ба үнэлгээ
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам (2016 оны 7-р сараас хойш)
MERIT	Монгол улс: Институцийн өөрчлөлт хийх замаар төрийн эрдэс баялгийн менежментийг сайжруулах санаачилга
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (2016 оны 7 сараас хойш)
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар (2016 оны 7 сараас хойш)
ТББ	Төрийн бус байгууллага
КДИСУ	Канад улсын Дэлхийн их сургуулиудын үйлчилгээ

1. УДИРТГАЛ

Канад улсын Засгийн газрын санхүүжилтээр Монгол улсад зургаан жилийн (2016-2022) хугацаанд хэрэгжиж буй “Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл” (MERIT) нь төрийн байгууллагуудын менежментийг сайжруулснаар олборлох салбарын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх үндсэн зорилготой.

MERIT төсөл нь Засгийн газраас олборлох салбарт хэрэгжүүлж буй бодлого, хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд төрийн яам, агентлагууд болон аймаг, сум¹ зэрэг төрийн захиргааны байгууллагуудын чадавхийг хөгжүүлэхэд анхаарч ажиллана. MERIT төслийн үр дүнгийн нэг багана нь орон нутгийн удирдлага буюу аймаг ба сумдын захиргаанаас тухайн нутагт явагдаж буй уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих, хууль сахиулах чадавхийг бэхжүүлэхэд төвлөрөн ажиллаж байна. Үндэсний болон аймаг, сумын төвшинд хийгдсэн өмнөх хэлэлцүүлгүүдийн үеэр төв болон орон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо болон мэдээлэл солилцоог сайжруулах, ялангуяа уурхайн нөлөөлөлд өртсөн нутгийн иргэд зэрэг оролцогч талуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд цогц уялдаа бүхий нэгдсэн зохицуулалт нэн шаардлагатай буй талаар олонтоо дурьдаж байв.

Энэхүү удирдамж нь уул уурхайн салбарын бодлого, хууль тогтоомжинд эрх зүйн өөрчлөлт хийх, орон нутгийн удирдлага болон уурхайн компаниудын хооронд хамтын ажиллагааны гэрээ байгуулах зэрэг олборлох салбарт олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх, шийдвэр гаргах үйл явцад талуудын оролцоог хангахад зөвлөмжөөр хангах зорилготой. Олон нийт, нийгэмд нөлөөлөх шийдвэр гаргах үед ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХЫГ ХУУЛИАР ЗОХИЦУУЛСАН, ЭСВЭЛ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА ШИЙДВЭРЛЭХ тохиолдолд иргэдийн санал авах, нийтийн ашиг сонирхлыг тусгуулах хэлэлцүүлэг зохион байгуулахад мөрдлөг болгоно.

Тус удирдамж нь олон нийтийн хэлэлцүүлгийг төлөвлөхөөс эхлээд эцсийн шийдвэр гаргах хүртэл, тухайлбал хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг хэлэлцүүлгийн үе шатуудыг бүхэлд нь авч үзсэн болно. Үндэсний болон орон нутгийн төвшинд хийгдэх олон нийтийн хэлэлцүүлгийг төрийн захиргааны ажилтнууд, иргэний нийгмийн зүтгэлтнүүд мөн нутгийн иргэд зэрэг харилцан адилгүй туршлага, мэдлэг бүхий хүмүүс удирдамж, заавар болгон ашиглах боломжтой.

2. ҮНДЭСЛЭЛ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Уул уурхай салбарын бодлого зохицуулалтанд өөрчлөлт хийх болон тусгай зөвшөөрөл олгох талаар Засгийн газраас гаргасан шийдвэр нь иргэдэд шууд нөлөөлж, нийгэмд эерэг, сөрөг үр дагаврыг бий болгож байдаг. Уурхайн нөлөөлөлд өртсөн иргэдийн хувьд тогтвортой хөгжлийг хангах нь засгийн газар, иргэд, уул уурхайн компаниудын нийтлэг сонирхол болдог. Түүнчлэн, уул уурхайгаас ашиг хүртэх, орон нутагт хэтийн болон ойрын үр өгөөжийг бий болгох сонирхол нэмэгдэхийн хэрээр эрх ашгаа хамгаалах, уурхайн компаниудтай харилцах нутгийн иргэдийн чадавхи улам сайжирч байна. Нутгийн иргэд шинээр эхэлж буй болон идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй уурхайн төслүүдээс ашиг хүртэж чадахгүй бол уурхайг хүчтэй эсэргүүцэх болсон. Иймд компаниуд уурхайн нөлөөллийг бууруулахын зэрэгцээ нутгийн иргэдийг хөгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай болсон.

Одоогийн байдлаар Монгол улсад уул уурхайтай холбоотой шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах, оролцогч талуудын хэлэлцээр, хамтын ажиллагааг үр дүнтэй зохицуулах институцын механизм дутагдалтай байна. Хууль тогтоох, төрийн бодлого хэрэгжүүлэх, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох болон орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулах зэрэгт олборлох салбарын оролцогч талууд (аж ахуйн нэгжүүд, нутгийн иргэд, иргэний нийгмийн гишүүд, Засгийн газрын яам, агентлагууд)-ын саналыг авч шийдвэрт тусгуулах оновчтой, тогтсон зохицуулалтын хэрэгсэл шаардлагатай байна. Түүнчлэн оролцогч талуудын хувьд эдгээр төрийн бодлого, зохицуулалтын өөрчлөлт, шийдвэрийн талаар тухай бүрд нь мэдээлэл авах, ашиг сонирхлоо илэрхийлэх, саналаа тусгуулах эрхтэй байдаг.

Уурхайн амьдралын мөчлөгийн бүх үе шатанд олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлж, мэдээллээр хангаж байх нь нэн чухал юм. Уурхай хаах, нөхөн сэргээлт хийх үе шатанд оролцогч талуудын санал авах хэлэлцүүлэг хийх нь олон сайн үр дагавар бий болгодог. Ялангуяа, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход уурхайн компани болон нөлөөлөлд өртөх иргэдийг төлөөлсөн нутгийн захиргааны байгууллага хооронд хамтын ажиллагааны гэрээ байгуулсан эсэхийг шалгуур болгон хуульчлуулах талаар Иргэний нийгмийн байгууллагууд нөлөөллийн ажлуудыг идэвхитэй хийж ирсэн. Нутгийн иргэд, тэр дундаа эмзэг бүлгийнхэн уурхайн үр өгөөжөөс хүртэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс хэрэгжихүйц, зорилтот бүлгийг хамарсан,

¹ Монгол улс нь засаг захиргааны хувьд 21 аймаг ба нийслэл Улаанбаатар хотод хуваагддаг. Харин аймгууд сумдад (дүүрэг), сумд багуудад (засаг захиргааны хамгийн бага нэгж) дахин хуваагддаг.

оролцоог хангасан гэрээг орон нутагт байгуулж, хэрэгжүүлэх нь тун чухал. ОНХАГ-г үр дүнтэй хэрэгжүүлэх нэг чухал хүчин зүйл бол тус гэрээг боловсруулах шатанд нутгийн эмэгтэй, эрэгтэй иргэд, малчдыг оролцуулах, тэдний ашиг сонирхлыг харгалзан тусгуулахад оршино. ОНХАГ-г байгуулж ажиллах тухай төрөөс хуульчилсан, мөн түүнчлэн нутгийн захиргаа, нөлөөлөлд өртсөн иргэдтэй харилцааг сайжруулах, орон нутгийн дэмжлэг авах ач холбогдлыг ухамсарласан уурхайн компаниуд ОНХАГ байгуулж ажиллах сонирхол нэмэгдэж байна. Уурхайн компаниуд, нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд, төв болон орон нутгийн захиргааны байгууллагууд, ТББ зэрэг харилцан адилгүй ашиг сонирхол бүхий оролцогч талууд ойлголцолд хүрэх, хамтын ажиллагааг бий болгоход энэхүү гэрээ чухал ач холбогдолтой.

3. ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ГЭЖ ЮУ ВЭ?

Олон нийтийн хэлэлцүүлэг нь хууль, эрх зүйн шинэчлэлт хийх, тусгай зөвшөөрөл олгох, уурхайн гэрээ байгуулах зэрэг шийдвэр гаргалтад эрх бүхий яам, агентлагууд, төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, үр ашгийг нэмэгдүүлэх чухал арга хэрэгсэл болдог. Олон нийттэй харилцах үндсэн гурван харилцааны хэлбэр байдаг бөгөөд эдгээрийг харилцан хослуулах, хавсрах зэргээр хэлэлцүүлэгт ашигладаг. Үүнд:

- ❖ **Мэдээлэх.** Аливаа шийдвэрийн талаар олон нийтэд мэдэгдэх нь засаглах ёсны үндсэн зарчим юм. Энэхүү харилцааны үед олон нийт мэдээллийг зөвхөн хүлээн авагч болдог, идэвхгүй, нэг талт мэдээллийн суваг гэсэн үг. Мэдээлэл хийх нь хэлэлцүүлгийн үед дангаараа ашиглагдахгүй, зөвхөн анхдагч алхам болдог. Урьдчилан мэдээлэх нь оролцогч талуудыг хэлэлцээр, зөвшилцөлд бэлтгэх хугацаа, боломжийг олгодог.
- ❖ **Зөвлөлдөх.** Тухайн шийдвэр нөлөөлж болох сонирхлын бүлгүүдийн саналыг сонсох идэвхитэй харилцааны хэлбэр. Энэхүү харилцаа нь хоёр талт мэдээллийн урсгал бөгөөд тухайн асуудлыг шинжилж, тодорхойлохоос эхлээд хүчин төгөлдөр хууль, зохицуулалтын хэрэгсэлд үнэлгээ хийх зэрэг олон нийтийн санал авах бүхий л үе шатанд ашиглагддаг. Зөвлөлдөх процессыг нэг удаагийн буюу үргэлжилсэн яриа хэлэлцээрийн хэлбэрээр зохион байгуулж болно. Хуулийн төсөл, бодлогын баримт бичиг боловсруулах, мөн уурхайн төслүүдэд тусгай зөвшөөрөл олгох зэрэг төрийн шийдвэрийг оновчтой байлгах үүднээс зөвлөлдөх процесст илүү их ач холбогдол өгөх болсон.
- ❖ **Оролцуулах.** Төрийн бодлого, зорилго тодорхойлох, хуулийн баримт бичиг боловсруулах, томоохон төсөл эхлүүлэхэд ашиг сонирхлын бүлгүүдийн идэвхитэй оролцоог хангах хэлбэр. Хуулийн хэрэгжилтийг сайжруулах, ойлголцол бий болгох, мөн улс төрийн дэмжлэг авахад олон нийтийн оролцоог хангах нь чухал холбогдолтой юм. Засгийн газраас хуулийн төсөл, бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжилтийг хангуулахад оролцогч талууд зөвлөлдөх зарчмаар үүрэг хариуцлагаа хуваалцах боломжийг олгодог.

Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах тухай энэхүү удирдамж нь доор дурдсан нийтлэг хандлагыг баримтална. Үүнд :

1. Оролцогч талуудын хэлэлцүүлэг, зөвлөлдөөн хийх процессыг сайжруулах
2. Хэлэлцүүлэг хийх практикийг стандартчлах, төрийн байгууллагуудад хэрэглэж хэвшүүлэх
3. Хэлэлцүүлэг зохион байгуулахад мөрдөх үндсэн зарчмууд, стандарт ба зорилгыг тодорхойлох
4. Цуглуулсан мэдээллийг ашиглах, тухайлбал хэлэлцүүлгийн үр дүн шийдвэрт хэрхэн туссан талаар хариу мэдээлэх талаар тайлбарлах
5. Төрийн ажилтнууд болон оролцогч талуудад ойлгомжтой хэлэлцүүлгийн ил тод, нээлттэй стандарт туршлага бий болгох
6. Оролцогч талуудын хүлээлтийг тодорхойлох

4. ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Хуулийн зохицуулалт болон уурхайн төслүүдийн талаар төрийн шийдвэр гаргахад гадаад, дотоодын оролцогч талуудын саналыг үр дүнтэй, товлосон хугацаанд авахын тулд нээлттэй, ил тод процессыг бий болгож, тухайн шийдвэрээр эрх ашиг нь шууд хөндөгдөх хувийн хэвшил, бизнесийн байгууллагууд, худалдааны нийгэмлэг гэх мэт сонирхлын бүлгүүдээс гадна хэрэглэгчид, байгаль орчны ТББ-ууд, бусад шатны засаг захиргаа зэрэг илүү өргөн цар хүрээний сонирхогч талуудын оролцоог бий болгох хэрэгтэй. Олон нийтийн хэлэлцүүлэг нь эрх зүйн зохицуулалтыг чанаржуулах, төрийн бодлого, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, мөн Засгийн газар болон иргэдийн хувьд хууль сахиулах өртөг зардлыг багасгах ач холбогдолтой.

Төрийн эрх бүхий байгууллага бодлого боловсруулах, тусгай зөвшөөрөл олгох шийдвэр гаргахын өмнө олон нийтийн хэлэлцүүлэг хийх нь олон чухал мэдээ баримтыг олж авах нөхцөлийг бүрдүүлдэг. Тухайн асуудлаар дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээлэл цуглуулах, өмнө нь тооцоолоогүй байсан бусад сонголтуудыг тодорхойлох, олон нийтийн хүлээлтийг хэмжих зэрэгт хэлэлцүүлгийн хэрэгцээ, ач холбогдол улам нэмэгдсээр байна.

- Шийдвэрийн төсөлд нөлөөллийн үнэлгээг хийх, зардлыг багасгахын тулд тухайн шийдвэр нөлөөлж болзошгүй бүх оролцогч талуудыг шийдвэр гаргах процесст ямар нэгэн хэлбэрээр оролцуулах нь хамгийн оновчтой, зөв шийдэл олоход тустай. Иймд олон нийтийн хэлэлцүүлэг нь шийдвэр гаргалтыг чанаржуулах хамгийн үр дүнтэй арга хэрэгслийн нэг юм. Хэлэлцүүлэг нь ил тод байдлыг сайжруулж, оновчтой шийдвэр гаргахыг дараах байдлаар нэмэгдүүлдэг. Үүнд:
- Шийдвэрийн нөлөөнд шууд өртөх бүлэг, хувь хүмүүсийн туршлага, үзэл бодлыг харгалзан, бусад боломжит хувилбаруудын талаар дэвшүүлсэн саналыг хэлэлцүүлэх
- Талуудын тэгш оролцоог хангах, тэдний ашиг сонирхлын зөрчилдөөнийг тэнцвэржүүлэхэд шийдвэр гаргагчдад туслах
- Урьдчилан тооцоолоогүй үр дагавар, практикт тулгамдаж буй асуудал бэрхшээлийг тодорхойлох
- Үр ашиг, зардал өртгийг тооцоолох, чанарын үнэлгээ хийх
- Төрийн байгууллагууд хоорондын зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах, тогтоох

Хэлэлцүүлгийн үйл явц нь хуулийн хэрэгжилтийг сайн дураар биелүүлэх хоёр үндсэн нөхцөлийг бүрдүүлдэг: Нэгдүгээрт, санал болгож буй өөрчлөлтийн талаар тодорхой хугацааны өмнө урьдчилан мэдэгдсэнээр талууд шаардлагатай арга хэмжээ авах хугацааг олгодог. Хоёрдугаарт, талууд тухайн шийдвэрийн дагуу хүлээх хариуцлагадаа өөриймсөг хандан хуулийн шаардлагыг биелүүлэх нь сайжирдаг.

Олон нийтийн хэлэлцүүлэг хийх нь хялбар бус процесс бөгөөд тодорхой хэмжээний санхүүжилт, эх үүсвэр, ур чадварыг шаардаж байдаг. Талуудын харилцан адилгүй эрх ашиг, сонирхлын зөрчилдөөний улмаас хэлэлцүүлгийн үеэр ээдрээтэй нөхцөл үүсдэг тул зохион байгуулагч, чиглүүлэгчийн зүгээс ихээхэн хүчин чармайлт, ур чадвар зарцуулах хэрэгтэй болдог.

5. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮНДСЭН ЗАРЧМУУД


Төрийн бодлого, хөтөлбөр, томоохон төслүүд боловсруулах, хэрэгжүүлэхэд олон нийтийн санал авах хэлэлцүүлэг өрнүүлэхэд дараах үндсэн зарчмуудыг баримтлах нь зүйтэй. Эдгээр зарчмууд нь төрийн захиргааны болон бусад олон нийтийн байгууллагуудын зүгээс хэрэгжихүйц, зорилтот бүлгийг хамарсан, үр дүнтэй, чанартай хэлэлцүүлэг өрнүүлэхэд ач холбогдолтой.

1. Хэлэлцүүлэг нь оролцоонд тулгуурласан, бүх талуудын ашиг сонирхлыг харгалзан үзсэн байх. Төрийн ажилтнууд оролцогч талуудын санал бодлыг бүрэн тусгуулах ач холбогдлыг ухамсарласан байх.
2. Хэлэлцүүлэг нь тухайн шийдвэрт нөлөөлж болзошгүй сонирхлын бүлгүүд буюу орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад оролцогч талуудын тэгш төлөөллийг хамруулсан байх.
3. Хэлэлцүүлгийг тухайн шийдвэр гаргах процессын аль болох эхний шатанд, тухайлбал ОНХАГ байгуулсаны дараа биш эхэнд нь зохион байгуулах ёстой.
4. Шаардлагатай мэдээллийг цуглуулсны үндсэн дээр зорилтот бүлгүүдэд хүрч чадах хэлэлцүүлгийн хэлбэр, төрлийг оновчтой сонгох.
5. Хэлэлцүүлгийн үйл явцыг ил тод, уялдаа, дэс дараалал бүхий, товлосон хугацаанд хийх хэрэгтэй. Хэлэлцүүлэгт оролцогчдод асуудлын мөн чанарыг ойлгох, санал өгөх хугацааг олгосон байх.
6. Хэлэлцүүлгийн өмнөх танилцуулга материалууд нь шаардлагатай суурь мэдээллийг багтаасан байхаас гадна цэгцтэй, ойлгомжтой байх.
7. Хэлэлцүүлгийн хамрах хүрээ, үзүүлэлтүүд нь оролцогчдод тодорхой байж, зөв хүлээлтийг үүсгэх. Саналыг хэрхэн хүлээн авах, тусгах талаар оролцогчдод зөв ойлголт өгсөн байх.
8. Төрийн байгууллагууд нь хэлэлцүүлгийн үр дүнд бүтээлчээр хандах буюу талуудын өгсөн санал шийдвэрт хэрхэн тусгасан талаар хариу мэдээлэх.
9. Захиргааны байгууллагууд нь жендэр, гарал үүсэл, нас, боловсролын төвшин, шашин шүтлэг зэргээр нь үл ялгаварласан эрх тэгш, харилцан хүндэтгэлтэйгээр хэлэлцүүлэгт оролцох нөхцөлийг бүрдүүлсэн байх.

6. ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЕ ШАТУУД

Олон нийтийн хэлэлцүүлэг хийх талаар нэлээн хэдэн гарын авлагууд хэвлэгдсэн байдаг ч хэлэлцүүлгийг хэрхэн үр дүнтэй, оновчтой зохион байгуулах талаар харилцан адилгүй зөвлөмж өгдөг. Хэлэлцүүлэг хийх зорилго, цар хүрээнээс хамааран нэр томьёо, үйл ажиллагааны дараалал, алхмууд өөр байх боловч энэхүү удирдамжинд тайлбарласан үндсэн алхмууд нь хэлэлцүүлэг, зөвлөлгөөнийг үр дүнтэй зохион байгуулахад зайлшгүй чухал юм.

Хэлэлцүүлгийг төлөвлөх нь хэлэлцүүлгийн хамгийн чухал үе шат бөгөөд олон нийтийг оролцуулах цогц төлөвлөгөө, стратеги боловсруулахад анхаарал хандуулах нь тун чухал.



1-р шат: Асуудлыг тодорхойлох, хүсч байгаа үр дүн

Тусгай зөвшөөрөл олгох, ОНХАГ байгуулах хэлэлцүүлэг зохион байгуулах гэх мэт зарим тохиолдолд хэлэлцүүлэг зохион байгуулах нь харьцангуй хялбар байж болно. Харин бодлогын өөрчлөлт хийх хэрэгцээг тодорхойлох, тухайн санал болгож буй өөрчлөлтийг хэрэгжүүлснээр бий болох үр дүнг үнэлэх нь заримдаа нилээд ярвигтай байдаг бөгөөд уг өөрчлөлтийг хэрхэн эхлүүлэх талаар зааварчилгаа өгсөн ч бүрэн ойлгогдохгүй байх нь олонтаа ажиглагддаг. Хэлэлцүүлэг хийх эхний шатанд тухайн асуудал болон санал болгож буй шийдлийн талаар зөв ойлголттой болох нь чухал. Эцсийн үр дүн анх төсөөлж байснаас тэс өөр байж болох ч энэхүү ажлыг чухам яагаад эхлүүлэх болсон талаар тодорхой ойлголттой байх хэрэгтэй.

Хэлэлцүүлгийн зорилгыг тодорхойлох нь

Чухал элементүүд:

- Хэлэлцүүлэг хийх үндсэн зорилго юу вэ?
- Ямар санал, санаачлагыг хэлэлцүүлэх, чухам ямар асуудлыг онцлон хэлэлцүүлэх вэ?
- Энэхүү хэлэлцүүлгийн үр дүнд ямар өөрчлөлт бий болох вэ?

Олон нийт болон талуудын оролцоог хангах арга механизм нь тухайн асуудлын онцлог, цар хүрээнээс хамааран харилцан адилгүй байна. Тиймээс хэлэлцүүлэх, санал авах асуудлын суурь нөхцөлд дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай.

Анхаарах зүйлс:

- Бодлого боловсруулах шатанд тухайн санаачилгын агуулга, цар хүрээ, хүлээгдэж буй үр дүн зэргийг тодорхойлох
- Хэлэлцүүлэгт бэлтгэж буй шийдвэрийн төсөл, санаачилгын талаар мэдлэг, мэдээлэлтэй байх
- Хэлэлцүүлгийн цар хүрээг тодорхойлох: ямар асуудалд голлож төвлөрөх, бодлогын төсөл боловсруулах бэлтгэл шатанд ямар хэлбэрээр нөлөөлж болох?
- Санал (субъектив – хувийн үзэл бодол) авах болон баримт мэдээлэл цуглуулах (объектив – бодит баримт) хоёрын ялгааг ойлгох.

2-р шат: Оролцогч талууд / зорилтот бүлгийг тодорхойлох нь

Хэлэлцүүлгийн бүхий л шатанд оролцогч талуудын хэрэгцээ шаардлага, ашиг сонирхолыг харгалзан үзэж хэлэлцүүлэг болон шийдвэр гаргах үйл явцад хэрхэн үр дүнтэй оролцуулах талаар анхаарах нь чухал юм. Хэлэлцүүлгийг чанартай сайн хийнэ гэдэг нь уул уурхайн төсөлтэй холбоотой гарч болзошгүй эрсдэл, нөлөөлөл болон боломжуудыг үнэлэх үүднээс оролцогч талуудтай зөвлөлдөж тухайн төслийн талаарх “бүрэн дүр зургийг гаргахад” оршино. Зорилтот бүлэг гэдэгт засгийн газрын яам, агентлагууд, орон нутгийн захиргаа, олон улсын байгууллага/иргэд, аж үйлдвэр, үндэсний ТББ-ууд, орон нутгийн ТББ-ууд болон олон нийт зэрэг багтахгаас гадна бусад холбогдох талууд байж болно.

Зорилтот бүлгүүдийг тогтоохоос гадна янз бүрийн нийгмийн бүлэглэлүүд, түүнчлэн жендэрийн мэдрэмжтэй оролцоог хангах талаар анхаарах нь зүйтэй. Тухайлбал, эрэгтэй эмэгтэй хүмүүс гэр бүл болон нийгмийн амьдралд өөр өөр үүрэг рольтой оролцдог. Тиймээс аливаа орон нутгийг хөгжүүлэх төсөл хөтөлбөрүүд тэдгээрийн гэр бүл, амьдралд хэрхэн нөлөөлөх талаар ялгаатай байр суурь, үзэл бодолтой байх болно. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд залуус, өндөр настнууд, үндэстний цөөнх зэрэг зарим хүмүүс эрх мэдэл, боломж бололцоо дутмаг байдаг учраас өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чадахгүй, илэрхийлсэн ч тэдний саналыг хүлээн авахгүй гэж боддог.

Чухал элементүүд:

- Тухайн төсөл буюу шийдвэрийн улмаас шууд болон дам нөлөөлөлд өртөх оролцогч талуудыг тодорхойлох
- Оролцогч талуудын ашиг сонирхол болон нөлөөллийн төвшинг үнэлэх

Оролцогч талуудыг тодорхойлох нь

Хэлэлцүүлэгт оролцуулах арга хэлбэрийг тодорхойлох, мэдээлэл түгээх, мэдээллийг боловсруулж эхлэхээс өмнө тухайн шийдвэрт шууд өртөх гол оролцогч талуудыг эхлээд тодорхойлох нь чухал байдаг. Төрийн бодлого, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх шийдвэрийн нөлөөнд өртөх буюу эрх ашиг нь шууд ба шууд бусаар хөндөгдөх гадаад, дотоодын байгууллага, бүлэг ба хувь хүмүүсийг оролцогч талууд хэмээн авч үзнэ. Өмнө дурдсанчлан, хамааралтай дотоод оролцогч талуудын оролцоо, санал чухал боловч энэхүү удирдамжийн үндсэн асуудал биш болно.

Оролцогч талуудыг тодорхойлоход янз бүрийн арга хэрэгсэл ашиглаж болно. Тухайлбал, хамтдаа санал бодлоо уралдуулах, уурхайн зураглал хийх, бүх оролцогч талуудын жагсаалт гаргах, өмнө хэрэгжсэн ижил төстэй төслүүдээс оролцогч талуудыг тодорхойлсон туршлагыг судлах. Өмнө хэрэгжсэн ижил төстэй төслүүдийг судлах нь оролцогч талуудын шинжилгээ хийхэд хугацаа хэмнэхээс гадна болзошгүй эрсдэл, аливаа шийдэгдээгүй асуудлын талаар таних боломжийг бүрдүүлнэ. Түүнчлэн, нөлөөллийн үнэлгээ, хэлэлцүүлэг / санал гомдлын бүртгэл, төслийн оролцогч талуудын жагсаалт, тайлан зэрэг бусад мэдээллийн эх үүсвэрүүдийг ашиглах боломжтой.

Оролцогч талуудын дүн шинжилгээ хийх нь

Дараагийн шатанд оролцогч талуудын ашиг сонирхол, зорилго, сэдэл, чадавхи, мөн тэдний нөлөөллийн төвшин (багаас их) зэргийг судлах хэрэгтэй. Талуудын ашиг сонирхол болон эрх мэдэл / нөлөөлөх чадварыг ойлгосны үндсэн дээрт тохирох хэлэлцүүлгийн арга, хэрэгслүүдийг сонгох хэрэгтэй.

Хэлэлцүүлэгт хамруулах оролцогч талуудын үнэлгээ хийх нь бодлого, хөтөлбөр, төсөл хэлэлцүүлэхэд өргөн хүрээний оролцогчидоос санал авах, асуудлыг тал бүрээс тодорхойлох, талуудын ойлголтыг нэмэгдүүлж дэмжлэг авах, хэрэгжилтийн явцад төсөл хөтөлбөрт өөриймсөг хандах хандлага, үр дүн, тогтвортой байдал сайжирдаг.

Оролцогч талуудыг тодорхойлох, ангилахад дараах хүчин зүйлүүдийг анхаарах хэрэгтэй:

- Санал болгож буй өөрчлөлт, шийдвэр нөлөөлж болзошгүй ашиг сонирхол бүхий бүлгүүдийг тодорхойлох.
- Хэлэлцүүлэх асуудлын хувьд сонирхол ба нөлөөллийн төвшингээр нь оролцогч талуудыг ангилах.
- Эмэгтэйчүүд, хүүхэд залуучууд, хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үндэсний цөөнх зэрэг эмзэг бүлгийн төлөөллийг тэгш оролцуулах.

3-р шат: Хэлэлцүүлгийн хугацааг тогтоох нь

Хэлэлцүүлэх асуудлын хамрах цар хүрээ, арга механизмийг харгалзсаны үндсэн дээр хугацааг төлөвлөх нь зүйтэй. Хэлэлцүүлгийн хугацааг тогтоохын тулд олон хүчин зүйлийг харгалзан үзэх ёстой бөгөөд төлөвлөлт хийх, хэрэгжүүлэх, хяналт үнэлгээ хийх зэрэгт зарцуулах хугацааг орхигдуулах эсвэл дутуу тооцоолох тохиолдол бий. Олон нийтийн хэлэлцүүлэг хийх төлөвлөгөө боловсруулах нь оролцооны бүхий л үе шат, үр дүнгийн шатлалыг нарийн төлөвлөх боломжийг олгодог. Хэлэлцүүлэгт шаардагдах хугацааг зөв тооцоолох нь оролцогч талуудад хүрч ажиллах, хэлэлцүүлэг өрнүүлэх, хэлэлцүүлгийн үр дүнг шинжлэх, олон нийтэд буцаан танилцуулах, мөн үр дүнд санал зөвлөмж хүлээн авах зэрэгт хангалттай хугацааг төлөвлөх ач холбогдолтой.

Хэлэлцүүлэг хийх хугацаа, хуваарь нь тухайн хэлэлцүүлгийн шалтгаан болон түүний төрөл хэлбэрээс шууд хамаарна (Жишээ нь, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэх мэт зарим хэлэлцүүлэг хийх хугацааг холбогдох хуулиар тогтоож өгсөн байдаг).

Хэлэлцүүлгийн нарийвчилсан хуваарийг боловсруулах нь

Чухал элементүүд:

- Оролцогч талуудад завсарын үр дүнгүүд ба төлөвлөгөөт хугацааг мэдэгдэх
- Хэлэлцүүлгийн өмнөх, дараах үеийг төлөвлөх

Анхаарах зүйлс:

- Шийдвэр гаргах эцсийн хугацаа
- Танилцуулга материалуудыг боловсруулах хугацаа
- Шаардлагатай тохиолдолд, бусад институт, агентлагуудтай харилцах мэдээлэл харилцааны стратеги боловсруулах хугацаа
- Хэлэлцүүлгийн оролцогчид буюу оролцогч талууд танилцуулга материалтай танилцаж ойлгох, зөвлөлдөх, саналаа бэлтгэх хугацаа
- Зөв цаг үеийг сонгох (улсын баяр, газар тариалан, хадлан бэлтгэлийн улирал зэргийг харгалзах)
- Хэлэлцүүлгийн байршил, аялал болон бэлтгэл ажилд шаардагдах хугацаа
- Хэлэлцүүлгийн үр дүнг дүгнэх ба үнэлэх, олон нийтэд хариу тайлагнахад шаардагдах хугацаа

4-р шат: Мэдээлэл боловсруулах нь

Шийдвэрлэхээр санал болгож буй асуудлын шалтгаан болон шийдлийг санал болгохоос гадна оролцогч талуудын онцлогт тохирсон мэдээллийн бүтээгдэхүүн, мессеж боловсруулах хэрэгтэй. Үр дүнтэй мессеж нь тухайн оролцогч талуудад ойлгомжтой, товч тодорхой байх бөгөөд хүлээн авагч талд хамааралтай байх төдийгүй тухайн хэлэлцүүлгийн зорилгод нийцсэн байх шаардлагатай.

Олон нийтэд зориулсан ерөнхий мэдээлэл буюу 1 ба түүнээс дээш зорилтот бүлэгт чиглэсэн дэлгэрэнгүй танилцуулга гэсэн 2 төрлийн багц мэдээллийг ихэвчлэн боловсруулдаг. Гол мессежүүдийг боловсруулахдаа тухайн санал болгож буй төсөл, санаачилгын талаар хүлээн авагч / оролцогч талуудын мэдлэг, ойлголтын төвшинг харгалзан үзэх нь зүйтэй. Тухайлбал, нийтэд хаягласан мэдээлэлд техникийн үг хэллэгийг хялбаршуулж ойлгомжтой байдлаар ашиглах хэрэгтэй. Харин мэдээллийн багц бүтээгдэхүүнд зар, хураангуй мэдээлэл болон дэлгэрэнгүй техникийн бичиг баримтууд, илтгэл танилцуулга зэрэг багтана.

Оролцогч талуудын хэрэгцээ сонирхолд тулгуурлан илгээх санал, мэдээ

Чухал элементүүд:

- Зорилтот бүлгүүд сонсоод, ойлгох, санал өгөхөд тохиромжтой цэгцтэй мэдээллийг хүргүүлэхийн тулд мэдээллийн агуулга, гол санаануудыг хэлэлцэж тохиролцох.
- Тухайн мэдээлэл ойлгомжтой, товч тодорхой, мөн хэлэлцүүлгийн зорилгод нийцэж байгаа эсэхийг нягтлан сайжруулах.
- Бэлтгэсэн мэдээлэл тухайн хэлэлцүүлгийн зорилго болон хүлээн авагч талуудын хэрэгцээнд нийцсэн хэвээр эсэхийг дахин нягталж, шаардлагатай бол шинэчлэх.

Анхаарах зүйлүүд:

- Санал болгож буй төсөл, санаачилгын талаар ерөнхий мэдээлэл (хэвлэлийн мэдээ), дэлгэрэнгүй танилцуулга (мэдээллийн хуудас) зэрэг олон төрлийн бичиг баримтуудыг боловсруулах.
- Оролцогч тал (олон нийт, хувийн хэвшил, ТББ, засгийн газрын бусад яам/агентлагууд, орон нутгийн засаг захиргаа) тус бүрийн тухайн төсөл, санаачилгын талаарх ойлголт, мэдлэгийн төвшин зэргийг харгалзан үзэх.

5-р шат: Мэдээлэл хүргэх ба санал авах хэлбэрүүд

Олон нийтийн хэлэлцүүлэг явуулах олон арга хэлбэр байдаг бөгөөд хэнийг хамруулж буй, хэр зэрэг албан ёсны арга хэмжээ болох, ямар мэдээлэл харилцааны хэрэгсэл ашиглаж буй зэргээс хамаарна. Хэлэлцүүлгийн арга хэлбэр тус бүр давуу болон сул талтай учраас бүх нөхцөл байдалд тохирох цорын ганц зөв жор гэж үгүй. Иймд хэлэлцүүлгийг үр дүнтэй хийх, цаашдын үр нөлөөг сайжруулах зорилгоор оролцогч талуудын хэрэгцээнд тулгуурлан олон янзын арга, техникүүдийг ашиглаж болно.

Мэдээллийн хүртээмж, тэгш оролцоог хангахын тулд мэдээллийн сувгуудыг оновчтой сонгож төлөвлөх нь чухал. Мэдээлэл түгээх олон арга, хэрэгсэл байх бөгөөд үүнд цаас буюу хэвлэмэл материал, цахим хэлбэр, хэвлэл мэдээллийн хэрэгсэл (сонин, радио, телевиз), олон нийтийн сүлжээ, интернетэд байршуулсан илтгэл, үндэсний болон орон нутгийн төвшинд уулзалт хэлэлцүүлэг хийх танилцуулга зэргийг дурьдаж болно. Санал, зөвлөмж авах хэлбэр нь уг мэдээллийг хүргэсэн хэлбэртэй төстэй байх хэрэгтэй. Жишээ нь, олон нийтийн сүлжээгээр дамжуулан мэдээлэл түгээсэн бол оролцогч талууд мөн олон нийтийн сүлжээ ашиглан саналаа өгөх боломжтой байх хэрэгтэй. Хүлээн авсан саналуудыг бүртгэж цуглуулах нь энэхүү үйл явцын нэн чухал хэсэг юм.

Хэлэлцүүлгийн арга, хэрэгслийг тодорхойлох, хүртээмжийг баталгаажуулах

Чухал элементүүд:

- Хэлэлцүүлгийн зорилго, оролцогч талууд, тухайн санаачилгын цар хүрээ, мөн чанар, шаардагдах цаг хугацаа, хөрөнгө нөөц зэрэгт тохируулан хэлэлцүүлэг хийх хэлбэрийг сонгоно.
- Хэлэлцүүлэг хийх арга хэмжээний хуваарь гармагц хэлэлцүүлэг хийх стратегийг нийтэд мэдээлэх, нийтлэх, шаардлагатай үед гарсан өөрчлөлтүүдийг дахиж мэдэгдэх.

Анхаарах зүйлүүд:

- Хэлэлцүүлгийн аргууд: олон нийтийг хамарсан өргөн цар хүрээ эсвэл тодорхой зорилтот бүлгийг хамрах хэлэлцүүлэг.
- Хэлэлцүүлгийн хэрэгсэл: хэлэлцүүлгийн аргаас хамаарч хэлэлцүүлгийн хэрэгслийг сонгох, хэлэлцүүлгийн хэрэгслийг оновчтой сонгохын тулд оролцогч талуудын мэдээлэл хүлээн авах болон хариу санал өгөх чадавхи, нөөц бололцоог харгалзан үзэх.
- Харилцах / оролцооны төвшин (бичгэн хэлэлцүүлэг үү аль эвсэл оролцогч талуудын арга хэмжээ юу? Онлайн орчинд хэлэлцүүлэг өрнүүлэх үү аль эсвэл интернетэд суурилсан өөр арга хэрэгсэл сонгох уу гэх мэт).
- Хэлний сонголт: Үгийн утга хэрэглээ буюу оролцогч талуудад ойлгомжтой үг хэллэг сонгох, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулах үед.
- Хэлэлцүүлгийн арга хэмжээ / уулзалтуудын хүртээмжтэй байдал.
- Хэлэлцүүлгийн арга хэрэгсэл болон хэлэлцүүлэг өрнүүлэх сувгийн хүртээмж: мэдээлэл харилцааны сувгийн сонголт.
- Цагийн мэдрэмж: хэлэлцүүлгийг товлосон цагт зохион байгуулах, зарим хэлэлцүүлгийг хуулиар тогтоосон хугацаанд багтаанд зохион байгуулж, олон нийтийн саналыг хүлээн авах ёстой байдаг;
- Санал болгож буй өөрчлөлт, санаачлагатай хамааралтай бүх санал гомдлуудыг бүртгэх, хөтлөх, ангилах.

6-р шат: Нэмэлт хэлэлцүүлэг хийх хэрэгцээ

Зарим ээдрээтэй, нөлөөллийн цар хүрээ ихтэй асуудлаар (томоохон барилга байгууламж барих аль эсвэл нэн чухал бодлогын төсөл гэх мэт) хэлэлцүүлэг өрнүүлэхэд олон тооны хоорондоо зөрчилдсөн санал хүлээн авах тохиолдол гардаг. Шийдвэрийг эцэслэн, нийтэд зарлахаас өмнө илгээсэн саналуудыг нэгтгэх нь ямар төвшинд, хэр зэрэг өөрчлөлт оруулах тухай нягтлах нь цаашид нэмэлт хэлэлцүүлэг хийх эсэхийг шийдэхэд тустай.

Шийдвэр гаргахын өмнө нөхцөл байдлыг үнэлэх нь

Чухал элементүүд:

- Хэлэлцүүлгийн эхний шатанд ямар чиглэлийн саналууд түлхүү ирсэн тохиолдолд цаашдын лавшруулсан хэлэлцүүлэг хийх хэрэгтэй гэдгийг урьдчилан тодорхойлсон байх.

Анхаарах зүйлүүд:

- Цугласан, зөрүүтэй саналуудын эх үүсвэр (оролцогч тал), шинж чанар, тоо зэргийг нягтлах.
- Санал болгож буй өөрчлөлт, шийдвэрийн эхний төсөлд дутагдаж буй гол асуудал, шийдлийг тодорхойлох.
- Хэлэлцүүлж буй эхний төсөлд нөлөөлөх гадны, хянах боломжгүй хүчин зүйлс (орон нутгийн гэрээг хэлэлцүүлэх үед холбогдох хуульд өөрчлөлт орох г.м).

7-р шат: Саналуудыг нэгтгэн дүгнэж эцсийн шийдвэрт тусгах нь

Хэлэлцүүлгийн явцад хяналт үнэлгээ хийснээр хэлэлцүүлэг амжилттай явагдаж байгаа эсэхийг үе шат тус бүрт нь хянаж улмаар хэлэлцүүлгийг шийдвэрийн цар хүрээ, зорилготой уялдуулах зорилгоор шаардлагатай өөрчлөлтийг тухай бүрт хийх нь чухал юм. Олон нийтийн хэлэлцүүлгийн нэг чухал хэсэг нь шийдвэр гаргагчид ирүүлсэн санал зөвлөмжтэй танилцаж шийдвэр гаргахад харгалзан үзсэн гэдгээ хариу мэдээлэх болно. Хяналт шинжилгээ хийх явцад оролцогчдоос хүлээн авсан санал хүсэлтийг тогтмол үнэлж байх хэрэгтэй. Тиймээс хэлэлцүүлгийн оролцогчдын саналыг цуглуулах, бүртгэх саналын товъёог бэлтгэх зохих процедурыг бий болгох нь шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй, ил тод мөн хүртээмжтэй болгоход чухал ач холбогдолтой. Үүний дүнд, хүлээж авсан бүх санал зөвлөмжүүдийг (ижил төстэй саналуудыг нэг бүлэг болгон багцлах) жагсааж тэдгээр нь эцсийн шийдвэрт тусгагдсан, тусгагдаагүй эсэхийг зохих үндэслэл, тайлбарын хамт оруулна.

Оролцогч талуудаас өгсөн саналуудыг үнэлэх нь

Чухал элементүүд:

- Хүлээн авсан санал зөвлөмжийг нягтлан шалгаж, утга санааг нь зөв ойлгосон эсэхийг баталгаажуулах
- Хүлээн авсан бүх саналд хариу тайлбар бэлтгэх
- Хүлээн авсан саналуудын үр дүн, хариу тайлбарыг нийтлэх, нийтэд мэдээлэх

Анхаарах зүйлүүд:

- Хүлээн авсан бүх саналуудыг ангилах, дотоод товъёог бэлтгэх
- Хүлээн авсан саналуудын үр дүн, хариу тайлбарыг хэрхэн нийтлэх (эцсийн шийдвэр гаргах, дахин хэлэлцүүлэг явуулах, хэлэлцүүлгээр санал болгосон асуудлыг буцаан татах) нийтэд мэдээлэх тухай шийдэх

8-р шат: Эцсийн шийдвэр болон түүний хэрэгжилтийн хуваарь / хүчин төгөлдөр болох өдрийг мэдэгдэх нь

Хэлэлцүүлгийн эцсийн шийдвэрийг бүх оролцогч талуудад мэдэгдэх хэрэгтэй. Тухайн шийдвэр нь цар хүрээний хувьд үндэсний аль эсвэл орон нутгийн төвшинд хэрэгжүүлэх бүхий үйл ажиллагаатай холбоотой байж болно. Үндэсний төвшний шийдвэр гаргалт нь нийт боловсруулалтын үйл явцад нөлөөлөх, салбар дундын бодлого зохицуулалт, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой. Харин аймаг сумдын төвшний шийдвэр нь тухайн төсөлтэй илүү хамааралтай байдаг. Тусгай зөвшөөрөл олгох, орон нутгийн хэмжээнд гэрээ хэлэлцээр байгуулахтай холбоотой хэлэлцүүлэг хийсэн тохиолдолд хэлэлцүүлгийн үр дүн, хариу тайлбар мэдэгдэл, гарсан шийдвэрийг нийтэд мэдээлснээр хэлэлцүүлгийн үйл явц дуусгавар болно. Харин бодлогын өөрчлөлт хийх гэж байгаа тохиолдолд бодлогын талаарх эцсийн шийдвэр нь хэлэлцүүлгийн төгсгөл гэхээсээ илүү мэдээлэл хүргэх, ухуулан сурталчлах шинэ үйл явцын эхлэл болдог. Хэлэлцүүлэгт ашигласан оролцооны арга хэрэгслийн үр ашгийг үнэлэх нь тухайн хэлэлцүүлгээс суралцах боломжийг давхар олгодог. Оролцооны практик ач холбогдол нь дутагдал, сул талыг засаж сайжруулах үнэлгээний арга хэрэгслийг төлөвлөн хэрэгжүүлж, тухайн оролцооноос суралцах, сургамж авахад оршино. Үүнд ирүүлсэн санал нь эцсийн шийдвэрт хэрхэн тусгагдсан талаар хэлэлцүүлгийн оролцогчдод хариу мэдээлэл өгч, тайлагнах мөн багтана.

Эцсийн шийдвэрийг хэрэгжүүлэх нь

Чухал элементүүд:

- Санал болгож буй шийдвэр, өөрчлөлтийн талаар ерөнхий мэдээлэл (хэвлэлийн мэдээ), хэлэлцүүлэх асуудлын хураангуй танилцуулга (мэдээллийн хуудас) мөн гаргасан эцсийн шийдвэрийн дэлгэрэнгүй танилцуулга зэрэг мэдээллийн бүтээгдхүүнүүд боловсруулах;
- Оролцооны үйл явцын үр дүнг үнэлэх хяналт шалгалтын арга, хэрэгслүүд
- Эцсийн шийдвэрийг бүх оролцогч талуудад мэдээлэх.

Анхаарах зүйлүүд:

- Эцсийн шийдвэрийг бүх оролцогч талуудад хариу мэдээлэх мэдээллийн хэрэгслүүд (цаас, цахим, уламжлалт мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ, интернет дээр байршуулсан илтгэл, үндэсний болон орон нутгийн төвшинд уулзалт, зөвлөлдөөн хийх).
- Бодлогын төсөл хэлэлцүүлсэн тохиолдолд тухайн шийдвэрийн нөлөөнд хамгийн ихээр өртөх оролцогч талууд зэрэг янз бүрийн зорилтот бүлгүүдэд чиглэсэн сургалт, мэдээллийн материалууд боловсруулах.

7. ШИЙДВЭР ГАРГАЛТЫН ДАРААХ АРГА ХЭМЖЭЭ

Ихэнх тохиолдолд эцсийн шийдвэр гаргаснаар тухайн асуудал дуусдаггүй. Хэлэлцүүлгийн үйл явц дууссаны дараа тухайн зөвлөлдөх процессын давуу болон сул талуудыг үнэлж тогтоох, цаашид сайжруулахад анхаарах ёстой. Ингэх нь хэлэлцүүлэг, зөвлөлдөөний үр өгөөжийг тогтоох, өмнөх туршлагаас суралцах, сайн туршлагуудыг тодорхойлоход ач тустай.

Шийдвэр гаргасны дараах арга хэмжээ нь хэлэлцүүлгийн үе шатанд хамаарахгүй боловч, гаргасан шийдвэрийн үр дүнг хэлэлцүүлгийн зорилготой харьцуулан дүгнэлт хийхэд чухал дараагийн алхам болно.

Хяналт үнэлгээ, шинжилгээ

Аливаа хэлэлцүүлгийн явцад болон дууссаны дараа хяналт үнэлгээ, шинжилгээ хийж байх нь нэн чухал байдаг. Шийдвэр гаргасны дараа үнэлгээ хийх нь тухайн хэлэлцүүлгийн эцсийн зорилго хангагдсан эсэхэд хариулт өгөхөөс гадна, бусад тооцоолоогүй үр дүн бий болсон эсэхийг тогтооход тусална.

Бодлого, зохицуулалтын өөрчлөлт хийх, эсвэл тусгай зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах гэдгээс үл хамааран хэлэлцүүлгийн явц, үр дүнд ямар нэгэн хэлбэрээр хяналт, үнэлгээг хийх нь зайлшгүй чухал. Жишээлбэл бодлогын өөрчлөлт нь анх залруулахаар зорьсон асуудлын хүрээнд эерэг өөрчлөлтийг авчирч чадсан уу? Тусгай зөвшөөрөл олгосон, гэрээ байгуулсан бол хууль эрх зүйн бичиг баримтуудад заасан нөхцөл, заалтуудыг мөрдөж байна уу?

- Хяналт үнэлгээний ажлыг боловсруулахад дараах асуудлыг харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд:
- Үнэлгээний зорилго нь юу вэ?
- Хэн юуны талаар мэдэхийг хүсч байна вэ? Хувь хүмүүс болон байгууллагууд тухайн үйл явцын ялгаатай хэсгүүдийг сонирхож байна уу?
- Ямар мэдээлэл цугларсан, ямар арга хэрэгсэл ашиглан санал, зөвлөмжийг хүлээж авсан бэ?
- Үнэлгээ хийхэд ямар нөөц (жишээ нь, цаг хугацаа, санхүүжилт, туршлагатай мэргэжилтэн) хөрөнгө шаардлагатай болох

Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нь оролцогч талуудын шийдвэр гаргах, хариуцлага нэмэгдүүлэх, суралцах, мөн оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх зэргээр тухайн хэлэлцүүлгийн зорилгыг хэрэгжүүлэхэд ач тустай.

Засвар өөрчлөлт хийх нь

Хэрэв ХШҮ-ний хийсний дүнд хүссэн үр дүндээ хүрч чадаагүй болох нь тогтоогдвол тухайн шийдвэрийг өөрчлөх шаардлагатай болно. Нэмэлт өөрчлөлтийн цар хүрээ мөн асуудлын хэр ярвигтай байдлаас хамааран засвар өөрчлөлтийг хэрхэн хийхийг тодорхойлно. Хэрэв өөрчлөлтийн нөлөөлөл жижиг аль эсвэл захиргааны шинж чанартай бол богино хэлэлцүүлгээр эсвэл нэмэлт хэлэлцүүлэг огт хийхгүйгээр өөрчлөлт хийх боломжтой. Харин нөлөөлөл ихтэй, томоохон хэмжээний өөрчлөлт хийх шаардлага үүсвэл олон нийтийн хэлэлцүүлэг хийх процессыг дахин эхлүүлэх шаардлагатай болно.

8. ХАВСРАЛТ

1-р хавсралт: Олборлох салбарт оролцогч талуудын хэлэлцүүлэг хийх хууль, эрх зүйн үндэслэл

Уул уурхайн шийдвэр гаргах үйл явцад орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх талаар иргэний нийгмийн байгууллагууд идэвхитэй нөлөөллийн ажил хэрэгжүүлсний дүнд уул уурхайн компаниуд орон нутгийг хөгжүүлэх талаар хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллах тухай 2009 оны Ашигт малтмалын тухай хуулинд тусгасан байдаг. Гэсэн ч сүүлийн жилүүдэд нутгийн иргэд уурхайн төсөл / компаниудтай байнгын зөрчилтэй байсаар ирсэн бөгөөд энэ нь гол төлөв хууль эрх зүйн зохицуулалт муу, яриа хэлэлцээр дутмаг мөн бодит бус хүлээлт үүсгэсэн зэрэгтэй холбоотой.

Ашигт малтмалын хуулинд зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн удирдлагатай орон нутаг хөгжүүлэх хамтын ажиллагааны гэрээ байгуулах ба тус гэрээнд байгаль хамгаалал, хөдөлмөр эрхлэлт мөн уурхайн төсөл хэрэгжих газрын дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх зэрэг асуудлуудыг тусгадаг. Ашигт малтмалын тухай хуульд буй тус ерөнхий заалтыг эс тооцвол уул уурхайн төсөлтэй холбоотойгоор олон нийтийн хэлэлцүүлэг явуулах, нутгийн иргэдийн оролцоог зохицуулдаг тусдаа бие даасан хууль, журам огт байдаггүй.

Гэхдээ хүчин төгөлдөр мөрдөгдөж буй байгаль орчны хуульд зааснаар уурхайн тусгай зөвшөөрөл авахын тулд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхийг шаарддаг ба үнэлгээ хийхэд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахыг заасан байдаг. Түүнчлэн, уурхайн хаалт болон байгаль орчны нөхөн сэргээлт хийхэд олон нийтийн хэлэлцүүлэг хийх нь чухал ач холбогдолтой гэж үздэг. Доорх хүснэгтэнд олон нийтийн хэлэлцүүлэг хийх, оролцоог хангах тухай хууль, эрх зүйн шаардлагуудыг оруулав.

Хүснэгт 1: Олон нийтийн хэлэлцүүлэг хийхийг зохицуулсан МУ-н хууль эрх зүйн заалтууд

Хууль / дүрэм журам	Хуулийн шаардлага
Монгол улсын Ашигт малтмалын тухай хуульд хамгийн сүүлд 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан ба тус хууль нь 2006 онд анх батлагдаж байсан. Энэ хуулийн зорилт нь Монгол улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Орон нутгийн гэрээ байгуулах талаар уг хуулийн 42 дугаар зүйлд: 42.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана. 42.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно. Ашигт малтмалын хуульд 2014 онд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Монгол улсын Ерөнхий сайд, УУ-н сайдын 2016 оны 3 сарын 28-ны өдрийн 179 дүгээр тушаалаар Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээний загварыг баталсан². Гэрээний загварын 4 дүгээр заалт ёсоор “Хамтын ажиллагааны хороо”-г 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр нутгийн захиргаа, уул уурхайн компани, иргэдийн төлөөллийн тэнцвэртэй төлөөлөл оролцуулан байгуулахаар заасан. Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ) нь иргэдийн төлөөллийг нэр дэвшүүлэх ба сумын засаг дарга нь тус хорооны гишүүдийг томилох үүрэгтэй. Стратегийн ач холбогдол бүхий ордыг ашиглах тохиолдолд орон нутаг хөгжүүлэх гэрээг уурхайн компани болон аймаг, хотын засаг дарга нарын хооронд байгуулна.	Орон нутгийн хөгжлийн гэрээ байгуулах
Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (БОНБУТХ) 1998 онд батлагдсан бөгөөд уг хуульд 2012 оны 5 дугаар сард байгаль орчны багц хуулийн хүрээнд өөрчлөлт оруулсан. Тус хуулинд заасны дагуу БОНБУ-ний тайланг бэлтгэхдээ тухайн төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн төлөөлөлтэй хийсэн хэлэлцүүлгийн хурлын тэмдэглэлийг хавсаргахыг шаарддаг. Шинэчилсэн хуулийн 17.4 дүгээр зүйлд заасны дагуу БОНБУ-г хийх эрх бүхий компани, хувь хүмүүс нь нутгийн захиргаа, төслийн нөлөөнд өртсөн бүх иргэдтэй уулзан тэдний саналыг авах шаардлагатай. 7.4.1-д заасны дагуу 17.4 заалтыг мөрдөөгүй төсөлд үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохгүй буюу өмнө олгогдсон зөвшөөрөл нь нь хүчингүй болно. Тиймээс төслийн нөлөөлөлд шууд өртөх иргэдийн саналыг авах нь төсөл хэрэгжүүлэх багийн хувьд нэн чухал юм. 2014 оны 1 сард Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын (хуучин нэршлээр) сайдын А-3 дугаар тогтоолоор “БОНБУ хийхэд олон нийтийн оролцоог хангах тухай” журмыг баталсан байдаг.	БОНБУ хийхэд олон нийтийн оролцоог хангах
Монгол улсын Захиргааны ерөнхий хууль нь 2015 оны 6 дугаар сарын 19-нд батлагдсан. Энэхүү хууль нь бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд нийтийн эрх ашгийг албан байгууллага, хувь хүний эрх ашгаас дээгүүр тавих эрх зүйн хүрээг тодорхойлсон. Уг хууль нь 2017 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хуулийн хүрээнд Захиргааны хэм хэмжээнд нийтийн сонсгол зохион байгуулах журмыг баталсан. 11 дүгээр заалтын дагуу, уул уурхайн гэрээ (жишээ нь, хөрөнгө оруулалтын гэрээ, тогтвортой байдлын гэрээ, бүтээгдэхүүн хуваах гэрээ, орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ, ашигт малтмал ашиглалтын гэрээ) нь захиргааны гэрээний төрөлд хамаарагддаг. Тиймээс олон нийтийн саналыг авахын тулд нийтийн сонсголыг зохион байгуулах шаардлагатай болсон.	Захиргааны шийдвэр нөлөөлж болзошгүй ашиг сонирхол бүхий бүлэг, хүмүүсийн оролцоог хангах
Нийтийн сонсголын тухай хууль тогтоомж нь 2016 оны 7 сарын 8-ны өдөр батлагдсан. Энэхүү хууль нь төрийн байгууллага, албан тушаалтан энэ хуульд заасан асуудлаар нийтийн сонсголыг зохион байгуулж төрийг удирдах хэрэгт иргэдийн оролцоог хангахад оршино. Төрийн бодлого боловсруулах, батлах, хэрэгжүүлэхэд иргэд, олон нийтийн оролцоог хангах тухай заасан анхны хууль. Нийтийн сонсгол нь хууль тогтоох, ерөнхий хяналтын, төсвийн хяналтын, захиргааны хэм хэмжээний, томилгооны болон төлөвлөлтийн ба орон нутгийн гэсэн хэлбэрүүдтэй байна. Тухайлбал, хууль тогтоох нийтийн сонсголыг тухайн хуулийг боловсруулах бэлтгэл шатанд зохион байгуулна.	Нийтийн сонсгол хийх

² Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын хавсралт, аж ахуйн нэгж, нутгийн захиргааны хоорондын байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар хийгдэх гэрээний загвар

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль хамгийн сүүлд 2012 оны 5 сард байгаль орчны багц хуулиудыг шинэчлэн батлах хүрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан. Тус нэмэлт өөрчлөлтөөр “бохирдуулагч нь төлбөр төлөх”, байгалийн нөөцийн хамтын менежмент зэрэг зарчмуудыг нэвтрүүлсэн байна.	Байгаль орчныг хамгаалахад иргэдийн оролцоог хангах
Монгол улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль нь 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр батлагдсан. Энэхүү хууль нь хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, батлах, хэрэгжүүлэх, цаашлаад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх зэргийг зохицуулна. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд оршино. Хөгжил, төлөвлөлтийн үндсэн суурь зарчмыг тодорхойлж үндэсний, бүс нутгийн мөн салбарын нэгдсэн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх, урт, дунд, богино хугацаанд уялдаа холбоог хангах, хөгжлийн бодлогыг боловсруулахад оршино.	Хөгжлийн төлөвлөлтөнд олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах
Хууль тогтоомжийн тухай хууль нь 2015 оны 5-р сард Улсын их хурал баталсан ба 2017 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү хууль нь засгийн газрын хууль болон орон нутгийн чанартай дүрэм журам боловсруулах үйл ажиллагааг зохицуулна. Хууль тогтоомжийн төсөл боловсруулахтай холбоотой олон нийтийн хэлэлцүүлэг нь оролцогч талуудыг хуулийн төсөл боловсруулахад оролцохыг дэмжих, эхний үе шатанд саналыг сонсох, зөвшилцөх замаар оролцох хэрэгтэй гэж 6 дугаар зүйлд заасан байна.	Хуулийн төслийг хэлэлцүүлэх
Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль нь 2011 оны 10 дугаар сарын 11-ний өдөр хэрэгжиж эхэлсэн. Энэхүү хууль нь улс төр, хууль эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг. Мөн зарим төрийн байгууллагуудын жендэрийн эрх тэгш байдлыг хангах үүргүүдийг тусгайлан зааж өгсөн байдаг.	Улс төр, хууль эрх зүй, эдийн засаг, болон нийгмийн харилцаанд жендэрийн эрх тэгш байдлыг хангах

2-р хавсралт. Жендэрийн тэгш байдлын тухай


Эдийн засгийн тогтвортой хөгжил гэдэг нь ихэвчлэн хөгжлийн төслүүдээс гадуур орхигдож үлддэг буюу уурхайгаас үүдэлтэй архидалт, гэр бүлийн хүчирхийлэл, бие үнэлэлт зэрэг нийгмийн сөрөг нөлөөллүүдэд илүүтэй өртдөг бүлэг хүмүүст анхаарал хандуулахыг хэлнэ. Үр дүнтэй хэлэлцүүлэг гэдэг нь уул уурхайн төслөөс гарах эрсдэл, үр дагавар болон бий болох боломжуудыг тодорхойлох зорилгоор өргөн цар хүрээний оролцогч талуудтай хэлэлцэн “цогц дүр зураг” бий болгохыг хэлнэ. Байгалийн нөөц ашиглалт нь соёл, нийгэм, эдийн засаг болон байгаль орчны олон хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдрал ахуйд ихээхэн нөлөөлж болно. Уул уурхайн хэлэлцүүлэг явуулахад жендэрийн тэгш байдал, олон янз байдлыг хангах тусгай баг байгуулж эмэгтэйчүүд болон эмзэг бүлгийн иргэдэд учрах нөлөөллийг үнэлэх, нэгтгэх, бүртгэх, мэдээлэх шаардлагатай.

Хүснэгт 2. Хэлэлцүүлэг хийхэд анхаарах жендэрийн асуудлууд

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТӨЛӨВЛӨЛТ	Үндэсний болон орон нутгийн төвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах ямар стратеги, бодлогын баримт бичгүүд байдаг вэ? Тухайлбал, аймгийн захиргаанаас баталсан жендэрийн эрх тэгш байдлын стратеги / дэд хөтөлбөр байдаг уу?
	Ямар нэгэн жендэрийн үнэлгээ, жендэрийн нөлөөллийн судалгаа хийгдсэн үү? Тухайлбал, бүс нутаг дахь эдийн засгийн хөгжлийн үр өгөөж, түүнээс үүдэлтэй боломжуудыг хүртэхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг хүйсээр ялгаварлан гадуурхах явдал гарч байгаа эсэхийг үнэлсэн олон улсын байгууллагын судалгаа байна уу?
	Уул уурхайн төслийн улмаас дордох буюу ноцтой асуудал үүсгэх магадлалтай хүний эрхийн зөрчил тус орон нутаг, бүс нутагт байна уу? Тухайлбал, хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, хүний наймаатай холбоотой хэрэг бүртгэгдсэн тохиолдол байна уу?
	Хүйсээр нь ангилсан мэдээлэл байна уу? Эрэгтэй, эмэгтэй хүмүүст учруулж буй харилцан ялгаатай нөлөөллийн талаар тус мэдээлэлд дурдсан байна уу? Жишээ нь, уул уурхайн салбарт ажиллаж буй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн цалинг харьцуулсан мэдээлэл бий эсэх?
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ҮЙЛ ЯВЦ	Хэлэлцүүлгийг зохион байгуулах ажлын хэсэгт эмэгтэй хүний төлөөлөл бий эсэх? Тухайн бүс нутгийн соёл болон жендэрийн асуудалд мэдрэмжтэй хандаж байна уу?
	Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангасан уу? Залуус, хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, үндэстний цөөнх зэрэг бусад бүлгийн хүмүүсийг мөн оролцуулж байна уу?
	Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийг оролцоход нь хязгаарлаж байгаа ямар нэгэн саад тогтор байна уу? Тухайлбал, зарим эрэгтэйчүүд мал хариулах ажилтай, харин эмэгтэйчүүд хүүхдээ хардаг тул оролцох боломжгүй байж мэднэ.
	Хэлэлцүүлгийг зохион байгуулахдаа эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн идэвхитэй оролцоог дэмжиж байна уу? Жишээ нь, эмэгтэйчүүд олон хүний өмнө аль эсвэл эрэгтэй улс төрийн өндөр албан тушаалтнуудын өмнө санал бодлоо чөлөөтэй илэрхийлж чадах уу?
БАРИМТЖУУЛАЛТ БА ТАЙЛАН	Олон хүний өмнө чөлөөтэй бодол санаагаа илэрхийлж чаддаггүй хүмүүсийг оролцуулах хэлэлцүүлгийн өөр арга хэлбэр байдаг уу? Жишээ нь, жижиг бүлгийн хэлэлцүүлэг явуулах, мөн залуу хүмүүсийн дуу хоолойг сонсох үүднээс бүлгийн хэлэлцүүлэгт оролцохыг урих.
	Хэлэлцүүлэгт оролцож байгаа хүмүүсийн санал бодлыг үнэн зөв тэмдэглэж авсан уу? Жишээ нь, өөр өөр санал зөвлөмжүүдийг бүртгэж авсан уу?
	Цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ хэт нэг талыг барьсан дүгнэлт хийхгүйн тулд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш оролцоог хангасан уу? Жишээ нь, өндөр настай эмэгтэйчүүдийн саналыг чухал биш хэмээн үзэж орхигдуулсан байж мэднэ.
	Хэлэлцүүлгийн үеэр оролцогчдын илэрхийлсэн саналыг үнэн зөвөөр тайланд оруулсан байна уу? Жишээ нь, орон нутагт эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж дутмаг байгаа, уул уурхайн төслийн улмаас ослын хэмжээ нэмэгдэж эрүүл мэндийн асуудлууд нэмэгдэж болзошгүй зэрэг ноцтой асуудлуудыг тусгасан уу?
	Зөвлөмж хэсэгт жендэр болон соёлын асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар санал оруулсан уу? Жишээ нь, эмэгтэй хүмүүс уурхайд ажилд ороход адил тэгш хандаггүй мөн эрэгтэйчүүд архи хэтрүүлэн хэрэглэх эрсдэл их байдаг зэрэг асуудлуудыг хөндсөн үү?

3-р хавсралт. Олон нийтийн тасралтгүй үргэлжлэх оролцоо

Зураг 1. Олон нийтийн тасралтгүй үргэлжлэх оролцоо



4-р хавсралт. Компанийн нийгмийн хариуцлагын хяналтын хуудас

Компанийн нийгмийн хариуцлагын хяналтын хуудас нь гадаад орнуудад уурхай эрхэлж байгаа Канадын уул уурхайн компаниудад зориулсан баримт бичиг бөгөөд учирч болзошгүй байгаль орчин, нийгэм болон зан заншлын хүндрэлтэй асуудлууд үүсэхээс сэргийлж, шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Тус хяналтын хуудас нь орон нутаг, нутгийн иргэдтэй харилцах үндсэн аргуудын талаар мэдлэг олгох, компаниуд нутгийн иргэдтэй сайн харилцаа тогтоох, аливаа нийгмийн эрсдлүүдийг харгалзан үзэхэд бэлтгэл болох зорилготой.


Уул уурхайн салбар тэр дундаа жижиг компаниуд уурхайн нийгмийн асуудлыг авч үзэх хэрэгтэй эсэхэд одоог хүртэл эргэлзэнгүй хандсаар байна. Зарим компаниуд орон нутаг, нутгийн иргэдтэй зөв харилцаа үүсгэх нь тэдний мэдлэг туршлага, хөрөнгө мөнгө, цаг хугацаа хүрэлцэхгүй хэмээн үздэг. Гэтэл зарим нь орон нутаг, нутгийн иргэдтэй системтэйгээр хамтран ажиллах нь зөвхөн иргэдийн хүлээлтийг нэмэгдүүлж, уурхайн төслийн зардлыг өсгөдөг хэмээн үздэг байна. Компанийн нийгмийн хариуцлага гэдэг нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхээс гадна эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой байдлыг хангах үүднээс сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг хамрах бөгөөд, салбарын зүгээс нийгмийн эрсдлийг сааруулахад чиглэсэн авч буй арга хэмжээ болно.

Хүснэгт 3: Таны хийж байгаа ажил хэрэгжиж байгаа гэдгийг та яаж мэдэх вэ?

САЙНЫ ШИНЖ ТЭМДЭГ	БУРУУ ЗҮГТ ЧИГЛЭЖ БҮЙ	ГАЗУУДАЛ
- Компанийн мэдээллийн самбар дээр байршуулсан шинэ мэдэгдлийг баллаж цохлоогүй байх. - Компаний эд хөрөнгийг сүйтгэх, хулгай хийх зэрэг асуудал бага. - Иргэдийн санал гомдол, үймээн (дуугүй байх нь илэрхийлэхгүй) бараг гарахгүй байх буюу буурах - Иргэд нь амьдралын чанар сайжирч буйгаа компанийн үйл ажиллагаатай холбон үздэг - Компанийн (сэтгүүлчид, ТББ, улс төрчид) эсрэг ухуулга хийх боловч нутгийн иргэдийн дэмжлэгийг авч чаддаггүй - Орон нутгийн зүгээс тавьж буй санал хүсэлт нь хувь хүн бус нийт иргэдэд үр шимээ өгдөг. - Орон нутгийн зүгээс тавьж буй санал хүсэлтүүд нь материаллаг зүйл шаардахаасаа илүү хувь хүний үр чадварыг хөгжүүлэхэд анхаардаг. - Ямар нэгэн хэрэг явдал гарахад олон нийтийн зүгээс хүч хэрэглэх зэрэг асуудал бага буюу огт үүсдэггүй. - Орон нутгийн иргэд аливаа асуудал үүсгэгч нарыг тодорхойлж, нутгийн иргэдийн дунд үүссэн цуу ярианы талаар компанийн ажилчдад (хамгаалалтын албанд) мэдэгддэг. - Нутгийн иргэд уурхайн талбай руу нэвтрэх боломжтой байж, компани хариу өгч ажилладаг болохыг өгүүлэх - Мэндлэхэд хүмүүс хариу далладаг.	- Нутгийн удирдлага болон өндөр настнууд тэднийг хүндэтгэхгүй байна хэмээн үздэг. - Ижил асуудлууд дахин дахин давтагдах. - Компанийн ажилчид нутгийн иргэдтэй уулзахад аюулгүй байдлыг мэдрэхгүй байх. - Компанийн зүгээс айлчлал хийхэд нутгийн иргэд хүйтэн хөндий хүлээн авах. - Компани, захиргааны нэгжийн харилцааг буруутгах. - Болсон үйл явдлын мөн чанартай харьцуулахад түүнээс хэтэрсэн их сөрөг хариу үйлдэл. - Нутгийн компанийг иргэд “дээрэнгүй”, орон нутагт санаа тавьдаггүй хэмээн буруу шаах. - Компани өөрсөдтэй нь харилцах ёстой хэмээн зүтгэх хэд хэдэн бүлэглэл үүссэн байх. - Компанийн зүгээс орон нутагт оруулах үр өгөөжийг хэлэлцэн тохиролцож бичгээр үйлдэж баталгаажуулахыг нутгийн иргэд шаардах. - Ажилд орох найдвар өвөртөлсөн иргэд компанийн үүдэнд цуглах.	- Хулгай өсөх хандлагатайг мэдээлэхгүй байх (компани хулгайн бай болох). - Ажил зогсолт. - Иргэдийн шаардлага нэмэгдэх, түрэмгий өнгө аястай болох - Осол гарахад өршөөл уучлалгүй хандах. - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сөрөг мэдээлэл цацах - Ажлын талбар дээр гэмт хэрэг ихсэх. - Орон нутаг буюу нутгийн иргэдийн хооронд зөрчил нэмэгдэх - Хорлон сүйтгэх үйл ажиллагаа. - Аюулгүй байдлыг цагдаа, цэргийн хүчээр зохицуулах. - Нутгийн иргэдийн зүгээс компани тэдний баялгийг цөлмөж байна хэмээн эсэргүүцэх.

Уурхайн хайгуул, барилга угсралт, олборлолт, баяжуулалт, уурхайн хаалт, байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайн хаалтын дараа гээд уурхайн төслийн бүхий л үе шатуудад олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах шаардлагатай. Уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн тодорхой үе шат бүрт олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлэг нь өөр өөр үүрэг гүйцэтгэдэг.

Зураг 2. Уурхайн амьдралын мөчлөгийн турш олон нийтийн хэлэлцүүлэг хийх жишээ



5-р хавсралт. Хэлэлцүүлгийн арга хэлбэрүүд

Доорх хүснэгтэнд олон төрлийн оролцогч талуудыг хамруулан үр дүнтэй хэлэлцүүлэг зохион байгуулах олон янзын аргуудын талаар танилцуулсан болно. Хэлэлцүүлэг зохион байгуулах аргуудыг санал, зөвлөмж цуглуулах болон хүмүүсийг нэг дор цуглуулах гэсэн хоёр ангилалд хувааж болно.

Хүснэгт 4. Хэлэлцүүлгийн арга хэлбэрүүдийн танилцуулга

1. Хариу өгөгдлийг цуглуулах аргууд			
ОЛОН НИЙТИЙН УУЛЗАЛТ: Оролцогч талууд, олон нийтийн төлөөллийг алба хаагч/зохион байгуулагч нартай уулзуулж, нэг болон олон тооны анхаарал татсан, санаа зовоосон асуудлуудаар хэлэлцэн зөвшилцөх. Олон нийтийн уулзалтаар олон хүмүүсийг хамруулах боломжийг олгодог. Уулзалтын үеэр жижиг бүлгүүдээр хэлэлцүүлэг зохион байгуулж, санал хүсэлтийг нь амаар авах боломжтой.	Сайн тал - Олон нийтэд анхаарал татсан, санааг нь зовоосон асуудлууд дээр санал бодлоо хэлэх боломж олгох; - Асуудлуудыг нүүр тулан тайлбарлах, нэмэлт мэдээлэл өгөх боломжийг олгодог; - Олон нийтийн санал бодлыг сонсох, мэдээлэл дээр үндэслэн хэлэлцүүлэг өрнүүлэх; - Цөөн тооны иргэдтэй газар илүү үр дүнтэй байдаг; - Яригдаж байгаа асуудалд хамааралгүй ч хэрэгцээтэй асуудалд анхаарал хандуулах тус болдог;	Сул тал - Хамааралгүй асуудлуудыг сөхөн ярих магадлалтай; - Хүмүүс өөрсдийнх нь хувийн асуудлыг хөндөөгүй, санааг нь зовоогоогүй бол оролцоо дутмаг байдаг; - Зарим хүмүүс олон хүмүүсийн өмнө үг хэлэхээс төвөгшөөдөг; - Хийж ирсэн хэлэлцүүлгийн загварууд нь оролцогчдын оруулах хувь нэмрийг хязгаарлаж, улмаар зөрчил маргаан үүсгэх магадлалтай; - Хэрвээ хэрүүл маргаан үүсвэл, энэ нь олон нийтэд буруу мэдээлэл сурталчилгаа болох магадлалтай;	
СУРГАЛТ / СЕМИНАР: Ихэнх тохиолдолд нэг болон түүнээс дээш хоног үргэлжилдэг томоохон сургалт, семинарын үеэр гол асуудал, сэдвээ жижиглэн дэд сэдвүүдийн хүрээнд авч хэлэлцдэг.	Сайн тал - Жижиг бүлгүүдийг хэлэлцүүлэг хийх, илтгэл тавих, асуулт ба хариулт, санал хүсэлт авах зэрэг боломжуудыг олгодог; - Хурал цуглааны хамгийн нээлттэй хэлбэр; - Оролцогчдод бусдын үзэл бодлыг сонсох боломж олгодог; - Олон оролцогч хамрагдах боломжтойгоос гадна; - Оролцогчид зөвшилцөлд хүрэхэд тусалдаг;	Сул тал - Зохион байгуулахад зардал ихтэй; - Олны өмнө ярих чадвартай цөөн хүмүүс хэлэлцүүлгийг давамгайлах магадлалтай; - Уулзалтыг хөтлөн зохион байгуулах хүмүүс чадвартай байх хэрэгтэй;	
ХОЁР ТАЛТ УУЛЗАЛТ: Гол төлөв төрийн төлөөлөл, оролцогч талын төлөөлөл нэг нэгээрээ уулздаг. Эдгээр уулзалтаар асуудлыг тогтоон тодорхойлох болон мэдлэгийн хүрээгээ тэлэх боломж олгодог.	Сайн тал - Оролцогч талын ямарваа нэг асуудлын талаар илүү гүнзгий ойлголтой болох болон; - Төрийн байгууллагаас гаргасан шийдвэр, чиглэлүүдийн талаар оролцогч талуудад мэдээлэл өгөх, гэгээрүүлэх боломж олгодог;	Сул тал - Уулзалтанд оролцож байгаа хүмүүсийн ярьж буй сэдвээр хязгаарлагдах магадлалтай; - Олон төрлийн оролцогч талууд цугларч асуудлаа хэлэлцэж, бие биенээсээ суралцах боломж олгодоггүй; - Бусдад нээлттэй биш, шударга бус харагдах магадлалтай;	
ЗОРИЛТОТ БҮЛГИЙН УУЛЗАЛТ: Өмнө нь сонгогдсон бүлэг хүмүүс тодорхой бодлого, төсөл хөтөлбөр, асуудлууд дээр өөрсдийн санаа бодлоо илэрхийлэх боломжийг хангасан бүтэцтэй үйл явц юм. Энэ үйл явц нь гол төлөв асуудлуудад анхаарлаа хандуулсан байдаг.	Сайн тал - Ямар нэг асуулт, сонирхол татсан асуудлыг хөндөх боломжтой; - Оролцогчдыг бусдын санал бодлыг сонсох, өөрсдийнх нь үзэл бодол бусдаас ямар хариу үйлдэл үзүүлж байгаа дээр дүгнэлт хийх; - Илүү дэлгэрэнгүй, нарийвчилсан хариултууд гарч ирэх боломжтой; - Тодорхой асуудал болон санал болгосон өөрчлөлтийн талаар гарч буй олон янзын үзэл бодлыг тодорхойлох боломжийг олгодог; - Хэлэлцүүлэг, туршилт, сорилто хийхээс өмнө нөхцөл байдлын судалгаа хийхэд ихээхэн хэрэг болох магадлалтай; - Хэлэлцүүлэг өндөрлөсний дараа авах арга хэмжээг илүү тодорхой болгох; - Харьцангуй хямд байх боломжтой;	Сул тал - Асуултууд нь тодорхой биш тохиолдолд бүлэг сэдвээсээ хазайх магадлалтай; - Нягт нямбай хийсэн нөхцөл байдлын судалгаа, уулзалтын бэлтгэл ажлаас ихээхэн хамааралтай; - Сонгогдсон бүлэг хүмүүс нь жижиг учир уулзалтаас гарсан дүгнэлт, олж авсан мэдээллийг ерөнхийлөн авч үзэх боломжгүй; - Жижиг судалгааны багийн ололтуудыг ерөнхийлөн авч ашиглах боломжгүй; - Уулзалтаас гарсан үзэл бодол нь олон нийтийг тэр чигээр нь төлөөлөхгүй; - Уулзалтуудыг ихэнх тохиолдолд гадны хүн хөтлөн чиглүүлдэг;	

ЯРИЛЦЛАГА / ГАНЦААРЧИЛСАН УУЛЗАЛТ: Ярилцлага авахаар бэлтгэгдсэн хүн өмнө нь сонгогдсон хүмүүсээс цуврал асуулт асууж, төсөл хөтөлбөр, бодлого гэх мэт тодорхой сэдвүүдээр мэдээлэл цуглуулдаг.	Сайн тал - Баримдлан тулгуурласан болон өөрийн үзэл бодолд тулгуурласан мэдээллийг авах боломжийг олгодог; - Асуудлын талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд тусгай; - Эдэрсээтэй асуудлуудын учрыг олоход нэмэртэй; - Ихэнх тохиолдолд нэг нэгээрээ үзлэдэг; - Илүү гүнзгийрүүлсэн мэдээллийг хурдан цуглуулах боломжтой; - Хэлэлцүүлгийн бэлтгэл ажилд хэрэглэгдэх боломжтой;	Сул тал - Уулзалтанд оролцогчид ихэнхдээ ганцаараа оролцдог, бусад хүмүүсийн үзэл бодлыг тусгааргүй учир нийтлэг байр суурийг бий болгох боломжгүй; - Цаг их зарцуулдаг; - Ярилцлага авч байгаа хүн нь үр чадвартай байх шаардлагатай; - Ярилцлага өгч буй хүний өрөөсгөл хандлага ярилцлагын үр дүнд нөлөөлөх магадлалтай;
ШУУРХАЙ УТСАН ХОЛБОО: Хүмүүсийн санал бодлыг хүлээн авах зориулалттай утасны дугаар. Энэ аргаар санал хураалт авч бас болно.	Сайн тал - Нүүр тулж уулзадаггүй учраас хүмүүс айж эмээлгүй санал бодлоо хуваалцах боломжтой; - Цаг хугацаа хэмнэхээс гадна; - Урт хугацааны турш хэрэглэгдэх боломжтой; - Гарч ирж буй асуудлуудаас шалтгаалан өөрөөр ашиглах боломжтой;	Сул тал - Өгч буй мэдээллийн үнэн зөв байдлыг хангахад тусгай мэдлэг шаардагдана; - Ирж байгаа мессеж, үг хэллэгээс хэрэгцээгүй, дэмий хэсгийг ялгаж салгахад хяналт тавин анхаарал хандуулах шаардлагатай;
САНАА БОДЛЫН СУДАЛГАА: Судалгаанд оролцогчдоор асуулгын асуултуудыг эрэмбэлүүлэх, олон хариултаас сонгуулах, нээлттэй асуултад хариулт авах замаар судалгааны мэдээлэл, оролцогчдын санал бодлыг (зарим тохиолдолд зөвөлгөө өгөх) цуглуулах үйл явц юм. Судалгааг шуудангаар, бичлэн, цахим хуудсаар болон утсаар авах боломжтой. Судалгаанууд ихэнх тохиолдолд нэг стандарттай учир судалгаанд оролцсон хүмүүсээс адилхан асуулт авдаг ба ингэснээр хариултуудыг үнэлэн дүгнэхэд үр дүнтэй байдаг.	Сайн тал - Энэ арга нь олон хүмүүсээс судалгаа авахад маш их хэрэгтэй байдаг; - Нэрээ мэдэгдэхгүй хүсэхгүй байгаа оролцогчийг хамруулдаг; - Тодорхой газартай холбогдолтой асуудлуудыг хөндөх боломжтой; - Шуудангаар, интернетээр, утсаар мэдээлэл цуглуулах боломжтой; - Харьцангуй хямд; - Хариултууд нь бүлэг хүмүүсийн үзэл бодол гэхээс илүү хувь хүний бодол дээр суурилсан байдаг;	Сул тал - Статистик дүн шинжилгээ хийхэд хэцүү; - Судалгааны хэрэгслийн хүчин төгөлдөр байдлыг тогтоохын тулд статистикийн зөвлөгөө шаардлагатай; - Үндэслэлтэй асуулт боловсруулахад мэргэжлийн үр чадвар шаардлагатай; - Судалгааны сурталчилгааг сайн хийхгүй бол судалгааны оролцоо хангалтгүй байх магадлалтай; - Судалгаанд оролцогчидтой харилцан ярилцах, санал бодлыг нь тусгах боломж бараг байдаггүй;
ОЛОН НИЙТИЙН ЗӨВЛӨХ ХОРОО: Хорооны гишүүд байнга явагддаг яриа хэлэлцүүлэг болон тодорхой зорилготой хэлэлцүүлэгт оролцдог.	Сайн тал - Байнга явагддаг хэлэлцүүлгээс гарах санал эсвэл мэргэжлийн мэдлэг чадвар нь шийдвэр гаргах үйл явцад шаардлагатай үед ашиг тустай; - Бодлого, хөтөлбөр эсвэл үйлчилгээг боловсруулахад саад болж байгаа асуудлын мөн чанар, нөлөөллийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх боломжтой; - Харилцааг бий болгох, сайжруулахад сайн нөлөөтэй; - Олон нийтийн том хэмжээний уулзалттай харьцуулахад зохион байгуулахад хялбар;	Сул тал - Бүтцийн хувьд маш нарийн ба үйл ажиллагааны нарийвчилсан ажлуудыг зохион байгуулах, төлөвлөх, гишүүдийг оролцуулахад хүчин чармайлт их шаардагддаг; - Олны өмнө сайн ярьдаг цөөн хүмүүс уулзалтыг давамгайлах боломжтой; - Төлөөлөл хангалтгүй гэх шүүмжлэлд өртөж болзошгүй; - Зөвлөхүүд нь шийдвэр гаргаж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэх магадлалтай; - Зөвлөхүүдээс хүлээх хүлээлт, тэдний эрх мэдэл, шийдвэр гаргахад ямар үүрэгтэй оролцох талаар ойлгомжтой чиглэл өгөх шаардлагатай;
САНАЛЫН ХУУДАС / АЖЛЫН ДЭВТЭР: Оролцогч талуудыг тавигдсан асуудлууд бэрхшээлүүдийн шийдлийг санал болгох боломжоор хангасан, сэдэвтэй хамааралтай мэдээллийг багтаасан цахим болон хэвлэж бэлдсэн материал.	Сайн тал - Төрийн байгууллагын эрх мэдэл, үүрэг амлалт болон зорилгыг илэрхийлэхэд тустай; - Асуудал, бэрхшээлийн талаар мэдэгдэх сайн арга ба ялангуяа ямарваа нэг асуудлын өөр өөр бүрдэл хэсгүүд нь тодорхой мэдлэг болон анхаарал хандуулах хэрэгцээтэй үед хэрэглэгддэг; - Оролцогч талууд асуудлуудын талаар бодох, чиглүүлсэн асуулт, мэдэгдэлд хариу өгөх боломж олгодог;	Сул тал - Шуудангаар илгээх шинэчилсэн түгээлтийн жагсаалт хэрэгтэй;

АРГА ХЭМЖЭЭ / АЯЛАН ТАНИЛЦУУЛГА: Арга хэмжээ, аялан танилцуулга нь бүлгийн хэлэлцүүлэг болон семинараас хэмжээ цар хүрээний хувьд том бөгөөд тодорхой хүмүүсийг сонгон урих боловч ихэнхдээ сонирхсон хүмүүс оролцож болдог. Арга хэмжээг бүлгийн хэлэлцүүлэг, санал асуулга явуулах зэрэг оролцогч талуудын хэлэлцүүлэг хийх бусад аргуудтай нэгтгэх боломжтой. Арга хэмжээ, аялан танилцуулгыг төслийн талаарх мэдээлэл түгээхэд ашиглаж болно.	Сайн тал - Нэг дор олон хүмүүсийг хэлэлцүүлэх, их олон тооны хүмүүсийн холбогдох мэдээллийг авах боломжтой; - Нэг дор чанарын болон тоон мэдээллийг цуглуулах боломжтой; - Өөр өөр байр суурь, үзэл бодолтой оролцогч талуудыг урих боломжтой;	Сул тал - Зохион байгуулахад өндөр өртөгтэй, цаг хугацаа их шаардана; - Зохион байгуулахад багтаамж сайтай газар болон туслах ажилтнууд хэрэгтэй; - Гүнд нь орж ярилцах боломж хязгаарлагдмал; - Хэлэлцүүлэг явуулахаас илүүтэйгээр үйлчилгээний талаар мэдээлэл, харилцаа үүсгэхэд тохиромжтой; - Тоон мэдээлэл бага цуглардаг ба ихэвчлэн дүгнэлт хийдэггүй;
ФОРУМ: Форум нь бүлэг аль эсвэл байгууллага төлөөлсөн хүмүүсийн уулзалт билээ. Форумын оролцогчид гол төлөв орон нутгийн иргэдийн, улс төрийн, мэргэжлийн, эдийн засгийн, нийгмийн бүлгүүдийн төлөөлөл байдаг.	Сайн тал - Энгийн арга хэмжээ нь хөдөлгөх хүч, хүчин чармайлт, идэвхтэй байдлыг үүсгэхэд тусалдаг ба форумын үйл ажиллагаа сайжрах тусам илүү өргөн хүрээний оролцоог дэмждэг; - Тодорхой бүлэг хүмүүсийн санаа зовоосон асуудалд анхаарал хандуулах замаар алслагдсан, хүрч ажиллахад бэрхшээлтэй бүлгийг хамруулахад үр дүнтэй; - Орон нутгийн тодорхой асуудлыг шийдвэрлэх боломжтой;	Сул тал - Ихэнхдээ олон нийт бус бүлгүүдээс гишүүдийн төлөөллийг хамруулдаг; - Үйл ажиллагаанд чиглэсэн бус яриа болоод үлдэх магадлалтай; - Дүрэмд баригдсан, хүнд сурталтай болох магадлалтай; - Тус тусын үүрэг, хариуцлагын талаар төөрөгдөл, зөрчил үүсэх магадлалтай;
ВЕБ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ: Вебд суурилсан үйл ажиллагаанууд нь хүмүүсийг хаана, хэзээ, ямар хугацаагаар оролцохоо шийдэх боломж олгодог.	Сайн тал - Хүмүүс өөрт таатай газар, цагтаа оролцох боломжтой; - Асрагч, өндөр настай хүмүүс, бага насны хүүхдэдтэй эцэг эхчүүд гэх мэт гэрээсээ гарах боломжгүй хүмүүст тун тохиромжтой; - Мэтгэлцэн зохион байгуулж санал бодлоо хуваалцах боломжтой; - Өртгийн хувьд боломжийн; - Олон тооны хүмүүст хүрч чаддаг; - Семинар, олон нийтийн уулзалтад оролцсоноос илүү бага цаг зарцуулна;	Сул тал - Интернет, компьютерын мэдлэг шаардлагатай; - Интернет ашиглах мэдээлэл харилцааны чадвар шаардлагатай; - Оролцоо, үйлдэл хийхэд дүрэм шаардлагатай; - Шаардлагатай бол хөгжүүлэх, удирдах, чиглүүлэх мэргэшсэн / сургалт явуулах хэрэгтэй; - Сонирхол татахын тулд олон нийтэд мэдээллэх хэрэгтэй. Зарим хүмүүс тулгамдаж сүрдэж болзошгүй;
ГУДАМЖНЫ ҮЗҮҮЛЭН: Гудамжинд ханан дээрх зураг үзүүлэн зэрэг олны анхаарал татах зүйлс багтдаг бөгөөд олон тооны хүмүүсийн санал бодлыг сонсоход ашигладаг. Төслийн газрын зураг, төлөвлөгөөний үзүүлэн зэргийг байршуулан, өнгөрч байгаа хүмүүсийн санал бодлыг асуух ба тодорхой асуудал, сэдвийн хүрээнд сонголт хийх саналаа илэрхийлэх боломжтой.	Сайн тал - Олон тооны хүмүүсийн саналыг цуглуулах боломжтой; - Хүмүүстэй харилцаа үүсгэдэг; - Оролцооны аргааг сонирхолыг бий болгодог; - Хэвийн үед энэ хэлэлцүүлэг зэрэг арга хэмжээнд оролцдоггүй хүмүүсийг хамруулах боломжтой;	Сул тал - Их хэмжээний мэдээлэл бий болгоно; - Урьдчилан төлөвлөж, бэлтгэл ажил хийх хэрэгтэй; - Хүмүүстэй харилцах хэд хэдэн чиглүүлэгчийг ажиллуулах шаардлагатай; - Арга хэмжээ нь цаг уурын байдлаас хамааралтай;

ЭВХЭМЭЛ ТАНИЛЦУУЛГА / МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ: Эвхэмэл танилцуулга нь аливаа асуудал болон талаар, үйлчилгээнд гарсан өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэх үр дүнтэй арга юм. Энэхүү аргыг дангаар нь аль эсвэл үзэсгэлэн, кампанит ажил зэрэгтэй хослуулан ашиглах боломжтой. Мэдээллийн товихимол нь илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх аль эсвэл удаан үргэлжлэх хэлэлцүүлгийн талаар шинэ мэдээлэл хүргэх зорилгоор ашиглагддаг. Түүнчлэн застийн газраас гаргасан хэлэлцүүлгийн баримт бичиг зэрэг урт, нарийн төвөгтэй баримт бичгийг тоймлон тайлбарлахад мөн ашиглаж болно.	Сайн тал - Дизайнхаа хувьд бүтээлч байх боломжтой; - Танил, ойлгоход хялбар; - Тодорхой бүлгүүдэд чиглэсэн байж болно; - Олон нийттэй урт хугацааны харилцаа үүсгэх боломжтой; - Өргөн цар хүрээний хүмүүст хүрэх буюу том газар нутгийг хамрах боломжтой; - Асуудлын талаарх шинэ мэдээллийг тухай бүрт нь хүргэх боломжтой; - Санал зөвлөмжийг нэгтгэхдээ тасалдаг хуудас ашиглах боломжтой;	Сул тал - Цаг хугацаа их шаардсан; - Тэвчээр их шаардсан; - Урт хугацааны хүчин чармайлт шаардлагатай; - Хэзгаарлагдмал хүрээний санал зөвлөмж авна; - Үр нөлөөг хэмжихэд хэцүү;
ИРГЭНИЙ САНАЛЫН КАРТ: Саналын карт нь жирийн карт буюу маягт бөгөөд олон нийт ямар нэгэн үйлчилгээ, асуудлын талаар санал бодлоо илэрхийлэхэд зориулагдсан. Саналын картыг албан байгууллагын хүлээн авах зэрэг олон нийтэд хүртээлтэй газар байрлуулдаг. Картын дизайны, хэлбэр дүрс нь чухал бөгөөд бөглөхөд хялбар нүдэнд өртмөөр картуудыг хүмүүс их хэрэглэдэг. Бөглөж байгаа хүний талаар нас, хүйс зэрэг энгийн мэдээллийг асуух ба энэ нь хандлагыг тодорхойлоход ашиглагддаг.	Сайн тал - Бөглөхөд шуурхай, энгийн, хямд; - Хүмүүст танил; - Асуудлыг оролцогчид нь тодорхойлон гаргаж ирдэг; - Оролцогчдод биечлэн хариу өгөх боломжтой; - Орон нутгийн талаархи мэдлэг, туршлага дээр тулгуурладаг; - Жижиг, том асуудлуудыг аль алинийг нь хөндөх боломжтой; - Үйлчилгээнд гарсан өөрчлөлтийн талаар олон нийтийн санал бодлыг мэдэх боломж олгодог; - Санал зөвлөмжийг зэрэгээр хүлээн авах соёлыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;	Сул тал - Биелэх боломжгүй, хийсвэр санал гарах магадлалтай; - Оролцоо бага байж мэднэ; - Оролцогчид олон нийтийг бүрэн төлөөлөхгүй байх талтай;
2. Хүмүүсийг цуглуулах арга		
ХУРАЛ ЗӨВШИЛЦӨӨН: Хоёр төрлийн хурал удирдах (панел) бүлгийг байгуулна. Нэг нь мэргэжилтнүүдээс бүрдсэн, харин нөгөөх нь асуудлын талаар санаа зовнисон иргэдийн төлөөлөөс бүрдсэн байна. Хүн амыг төлөөлсөн иргэдийн бүлэг нь асуудлын талаар мэтгэлцэж өөрсдийн хүлээлт, санаа зовоосон асуудал болон зөвлөмж зэргийг багтаасан тайлан гаргана. Иргэдийн бүлэг мэдээлэл уншиж, гол асуултуудаа бэлтгэх зэргээр урьдчилан бэлтгэлээ хангадаг. Харин мэргэжилтнүүдийн хэсэг нь илтгэл тавьж асуултуудад хариу өгдөг. Хурал нь олон нийтэд нээлттэй байдаг.	Сайн тал - Олон нийт, мэргэжилтнүүд, улс төрчид, Застийн газар хооронд хэлэлцүүлэг өрнүүлдэг; - Техникийн аль эсвэл шинжлэх ухааны шинж чанартай орон нутгийн болон үндэсний хэмжээний асуудлыг шийдэхэд хэрэглэж болно; - Иргэдэд зөвлөмж бүхий баримт бичиг боловсруулан гаргах боломж олгодог; - Хэвлэлийн анхаарлыг татах боломжтой;	Сул тал - Хурал удирдах бүлгүүдийг үүсгэхэд хөрөнгө мөнгө, цаг хугацаа шаардагдана; - Аль аль хурал удирдах бүлэг нь бэлтгэлээ сайн хангасан байх шаардлагатай; - Хэвлэлийн анхаарлыг татах боломжтой;

ДУГУЙ ШИРЭЭНИЙ УЛЗАЛТ: Дугуй ширээний улзалт нь зөвшилцөлд хүрэх нэг хэрэгсэл байж болно. Энэ төрлийн арга хэмжээнд олон талт оролцогч талууд хамрагдах бөгөөд зөвшилцөлд тулгуурладаг учраас орон нутгийн байгаль орчин, эдийн засаг, нийгмийн тогтвортой байдлыг хангах хамтын ажиллагааг бий болгодог. Бизнесийн төлөөлөл, нутгийн иргэд гээд бүх оролцогчид адил тэгш байх үндсэн зарчимтай (салбарын төлөөлөл, засгийн газрын төлөөлөл, төрийн бус байгууллага)	Сайн тал - Хүмүүс бүгд адил тэгш үүрэг оролцоотой байдаг; - Нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлж аливаа асуудал, саад тотгорыг задлан авч үздэг; - Хүмүүст бус асуудалд анхаарлаа хандуулан авч үздэг; - Шинэлэг шийдэл бий болгох магадлалтай; - Зөвхөн нэг талд бус аль аль талдаа ээлтэй (хохирогчгүй) шийдлийг олоход чиглэдэг;	Сул тал - Оролцогчид нь академийн хүмүүс, мэргэжилтэн зэрэг өргөн хүрээний хүмүүсийг оруулахаас сэргийлдэг; - Нухацтай бэлтгэл шаардлагатай; - Өндөр үр чадвартай чиглүүлэгч хэрэгтэй; - Эрх мэдэл бүхий элит, нийгмийн бүлгүүдийн давамгайлалд өртөх магадлалтай;
АЖЛЫН ХЭСЭГ: Ямар нэгэн асуудлын талаар судалж байгаа мэргэжлийн баг, оролцогч талуудын төлөөлөл. Ажлын хэсэг нь зөвлөмж бүхий тайлан бэлтгэн гаргадаг.	Сайн тал - Мэргэжилтнүүдэд ярилцлагыг удирдах боломж олгодог; - Олон нийтийн өмнө ил тод байх үед хэрэгтэй; - Гуравдагч талын зөвлөгөө хэрэгцээтэй; - Нийгмийн өргөн хүрээг хамарсан үр дагавар дагуулах ээдрээтэй асуудлуудад тохирсон;	Сул тал - Үйл ажиллагааг зохион байгуулахад ихээхэн хүчин чармайлт болон цаг хугацаа шаардлагатай; - Тусгай сонирхлын бүлгийн талд үйлчилж байгаа мэт өрөөсгөл хандлага төрүүлэх магадлалтай; - Зөвлөмж, шаардлага хоёрын хооронд зөрүү гарах магадлалтай ба үүнээс үүдээд зөвлөмжүүд хэрэгжихгүй байх магадлалтай;
ЦАХИМ ХУРАЛ: Компьютерын сүлжээгээр бүлгийн шийдвэрийг дэмжих програм ашиглан нүүр нүүрээ харан улзалт хийн асуудлыг шийдэх, стратеги төлөвлөгөө боловсруулах, зөрчлийг арилгах, эрэмбэ дараалал үүсгэх, зөвшилцөлд хүрэх ажлуудыг хийх.	Сайн тал - Санал өгөхдөө нэрээ нууцлах боломжтой ба ингэснээр эрх тэгш оролцоог сайжруулдаг; - Хувь хүнээс илүүтэйгээр асуудалд анхаарал илүү ихээр хандуулдаг; - Саналууд хурлын явцад тэмдэглэгддэг учир дараа нь шивж оруулах шаардлагагүй; - Олон оролцогчдоос нэгэн зэрэг саналуудыг нь авах бололцоог олгодог; - Хэлэлцүүлгийн бэлтгэл ажилд ашиглагдах боломжтой;	Сул тал - Чиглүүлэгч нь програм хангамжийн талаар мэдлэгтэй байх шаардлагатай; - Чиглүүлэгч нь ярихын зэрэгцээ техник технологийн ажиллагаагаа тэнцвэртэй хангаж ажиллах хэрэгтэй; - Хуралд оролцохдоо болон харилцан ярилцахдаа тодорхой дүрмийг баримтлах шаардлагатай; - Хуралд оролцоход компьютер дээр бичих чадвартай байх эсвэл бичиж чаддаг хүнээс тусалцаа авах шаардлагатай;
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛЛИЙН ХЭСЭГ: Хүн амыг бүрэн төлөөлсөн хэдэн зуун иргэдээс бүрдсэн бүлэг төрөөс ирүүлсэн саналуудад хариу өгдөг. Бүлгийг санамсаргүй түүврийн аргаар эсвэл мэдлэг, сонирхол дээр нь үндэслэн сонгон авч болно.	Сайн тал - Үрт хугацааны туршид тоон болон чанарын мэдээллийн эх үүсвэрээр ашиглах боломжтой; - Хүмүүс нь биечлэн уулзах шаардлагагүй;	Сул тал - Хэрвээ тогтмол хэрэглэгдэхгүй бол анх үүсгэн байгуулахад өртөг өндөртэй; - Гишүүдийн дунд харилцан итгэлцэл, нэгдсэн ойлголт, итгэл үнэмшил бий болохгүй байх магадлалтай;
СУДАЛГААНЫ БАГ: Цөөн тооны хүнээс (5-20 хүн) бүрдсэн, урьдчилан сонгогдсон оролцогчид тогтмол уулзаж асуудлуудыг авч хэлэлцдэг. Ихэнх тохиолдолд туршлагатай чиглүүлэгч байдаг ба хэлэлцүүлэгт оролцохдоо баримтлах дүрэмтэй байдаг.	Сайн тал - Цаг хугацаа өнгөрөхийн хэрээр оролцогчид хэлэлцүүлэгт илүү хяналт сайтай, хариуцлагатай оролцдог; - Зохион байгуулахад энгийн бөгөөд хялбар; - Өртөг багатай; - Орон нутгийн нөөц бололцоо, санал санаачлагыг ашиглах боломжид түшиглэдэг;	Сул тал - Цөөн тооны хүнээс бүрддэг учир нутгийн иргэдийг бүрэн төлөөлж чаддаггүй;

СУДАЛГААНЫ БАГА ХУРАЛ : Өөр өөрийн үзэл бодолтой олон тооны урилдан ирсэн хүмүүсээс (60-70 хүн) бүрдсэн бүлэг. Бүлгийн гол зорилго нь мэдээлэл хуваалцаж харилцан ойлголцолтой болсноор өөрсдийн хүсэн хүлээсэн ирээдүйг бүтээх юм. Бага хурлын салбар хурлуудад төрийн, салбарын болон хэрэглэгч гэх мэт олон төрлийн төлөөлөл оролцдог.	Сайн тал - Орон нутгийн асуудлыг авч хэлэлцэхдээ тухайн нутгийн иргэдийг оролцуулан шийдвэрлэхэд тохиромжтой; - Нийтлэг ойлголт бий болгоход тустай; - Оролцогчид урьдаар сургалтанд хамрагдах шаардлагагүй бөгөөд цаг хугацаа бага үед ашиглахад тохиромжтой;	Сул тал - Иргэдийн төлөөллийг бүрэн хангасан байдлаар зохион байгуулахад бэрхшээлтэй; - Нэмэлт судалгаа хийх хүсэлт гарч болзошгүй;
ТИНК ТАНК / ЭРДЭМТГИЙН БАГ: Тулгараад буй асуудлыг шийдвэрлэхийн тулд мэдлэг, чадвар бүхий хүмүүсээс бүрдсэн том эсвэл жижиг бүлгийг байгуулдаг. Энэхүү үйл ажиллагаа нь нэгээс гурван өдөр үргэлжлэх боломжтой.	Сайн тал - Бүтэцлэг сэтгэлгээ ашиглах боломжтой; - Эдэрэгтэй асуудлыг шийдэхэд тустай; - Гуравдагч этгээдээс зөвлөмж авах шаардлагатай үед тун хэрэгтэй;	Сул тал - Оролцогчдын сонголтоос хамаарна; - Олон нийтийн санал бодлыг илэрхийлэхэд зөвхөн мэргэжилтний санаан дээр тулгуурлаж болохгүй; - Зөвхөн мэргэжилтнүүдийн мэдлэг, санал бодол тулгуурласан тул олон нийтийн дэмжлэг авахгүй байж мэднэ;
ШИЙДВЭР ОЛОХ СЕМИНАР: Санал бодол өөр өөр бүх ашиг сонирхлыг илэрхийлсэн хүмүүсийг цуглуулсан, асуудалд шийдэл олох семинар.	Сайн тал - Олон өөр янзын хүмүүсийг багтаасан бүлгүүдийг цуглуулан асуудлыг шийдүүлдэг; - Богино хугацаанд зөвшилцөлд хүрэх шаардлагатай үед тун хэрэгтэй арга; - Оролцогчдод өөр өөр, эсрэг талын байр суурийг ойлгож, мэдэхэд нь тусалдаг;	Сул тал - Төлөөлсөнөөс илүү удаан үргэлжлэх магадлалтай; - Зөвшилцөлд хүрч байж шийдвэр гаргадаг. Тиймээс хүн бүр хүлээн зөвшөөрөх дундын шийдлийг олоход бэрх байж мэднэ; - Захиргааг үр дүнг хүлээн зөвшөөрөх эсвэл нэр хүндээ алдах гэсэн сонголтыг хүчээр тулгах;
ЗӨВШИЛДӨХ САНАЛ АСУУЛГА: Санал асуулга, хурал зөвлөгөөн, дугуй ширээний уулзалт зэргийг хослуулсан арга юм. Тус үйл явцын эхэнд санаасаргүй түүврийн аргаар сонгогдсон бүлэг хүмүүс (40-100) санал асуулга бөглөнө. Дараагаар нь оролцогчдод олон янзын хувилбар бүхий баримт бичгийг, тус хувилбарыг дэмжих, няцаах аргуудыг хамт өгнө. Оролцогчид нь сайн тал, муу талуудыг нь мэтэлцэнэ. Сүүлд нь оролцогчид хоёр дахь асуудлыг гүйцээгээд эхний ойлголтоос өөрчлөгдсөн зүйл байгаа эсэх үүний шалтгааны талаар үнэлж дүгнэнэ.	Сайн тал - Асуудал нь тодорхой байна; - Албан болон албан бус харилцаа үүсгэж болно; - Түршлага, мэдлэгээ хуваалцах мэргэжилтнүүдийг хамруулж болно; - Оролцогчдод асуудлын талаар мэдээлэл авах боломж олгодог; - Оролцогчдыг яагаад ямар нэг үзэл санааг дэмжих болсноо тайлбарлахыг шаарддаг; - Оролцогчдийн байр суурь хэрхэн өөрчлөгдсөнийг хянах боломжтой;	Сул тал - Төлөвлөх, хэрэгжүүлэх, эцсийн тайланг боловсруулахад цаг хугацаа, хөрөнгө мөнгө их шаардлагатай; - Харьцангуй шинэ арга техник учраас туршлагатай чиглүүлэгч хэрэгтэй; - Нийт хүн амыг төлөөлөх түүвэр дээр суурилсан учир ээдрээтэй;
ДЕЛФИ ТООЦООЛЛОЛ: Тухайн асуудлын талаар өөр өөр байр суурьтай бүлэг хүмүүсийг сонгож авдаг. Оролцогчид нь саналаа хэлж, асуудлын талаар ярилцдаг. Ярилцсаны дараа, бүлгийн гишүүд асуудлын талаар санал бодол, хариугаа нэрээ нуун илэрхийлдэг. Зөвшилцөл хүрэх хүртэл санал солилцох ажиллагаа үргэлжилнэ.	Сайн тал - Өөр өөр саналын талаар ойлголтоо болж, буулт хийхийг дэмждэг; - Харилцан тохиролцсон дундын шийдэлд хүрэхэд анхаардаг;	Сул тал - Цаг их авна; - Оролцогчид бодлоо өөрчлөн, олонхын саналыг дэмжих магадлалтай; - Харилцан зөвшилцөлд хүрэх сонирхолгүй бүлэг хүмүүсийн хувьд тохиромжгүй арга;

9. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Оролцогч талуудын хэлэлцүүлэг – Нэгдүгээр хэсэг, Олон улсын санхүүгийн корпораци
2. Олон нийтийн хэлэлцүүлгийн ерөнхий мэдээлэл, OECD/OCDE, Эдийн засаг хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)
3. Гадаадад үйл ажиллагаа явуулж байгаа Канадын уул уурхайн компаниудын Компанийн нийгмийн хариуцлагын (KNX) жагсаалт (2015)
4. Хэлэлцүүлгийн хэрэгслийн хайрцаг >> Хэлэлцүүлэг явуулах зааварчилгаа (2004 оны 3 дугаар сар), Фишерийс энд Ошиэнс Канада
5. Уул уурхай, “Нийгмийн лиценз” ба орон нутгийн гэрээ Монгол улсад, Д.Бямбажав, Уул уурхайн салбарын нийгмийн хариуцлагын төв, Квинслендийн их сургууль, Австрали улс
6. Монгол улсын Уул уурхайн хууль (2015)
7. Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)
8. Монгол улсын Захиргааны ерөнхий хууль (2015)
9. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль (2012)
10. Монгол улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль (2015)
11. Монгол улсын Хууль тогтоомжийн тухай хууль (2015)
12. Монгол улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)

Ашигласан материалын линк

- ❖ Байгаль орчны үнэлгээнд олон нийтийн хэлэлцүүлгийн үүрэг:
Нэгдүгээр хэсгийн тайлан, 2015 оны 12 дугаар сар
<file:///C:/Users/User/Desktop/url.htm>
- ❖ БОҮГ (ЕАО) – Балди Ридж салбарын төслийн баримт:
<https://projects.eao.gov.bc.ca/p/baldy-ridge-extension/docs>
- ❖ БОҮГ (ЕАО) – Байгаль орчны ажлын олон нийтийн оролцоо:
<http://www.eao.gov.bc.ca/participation.html><https://www.aer.ca/rules-and-regulations/manuals>
- ❖ АЭНЗГ (AER) – Эрчим хүчний салбарын зөрчлийн зааварчилгаа ба бусад зөрчил арилгах хөтөлбөрүүд, 2013 оны 6 дугаар сар
<https://www.aer.ca/rules-and-regulations/manuals>
- ❖ АЭНЗГ (AER) – Албертагийн эрчим хүчний зохицуулах газрын сонсгох үйл ажиллагаа, 2013 оны 6 дугаар сар
<https://www.aer.ca/rules-and-regulations/manuals>